

ҮАГ-ын Удирдлагын зөвлөл болон ОХУ-ын  
Тооцооны танхимын Коллегийн хамтарсан  
хуралдаанаар батлав.  
2008 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр  
Протокол № 47К (624)

**Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн 2003-2005 оны санхүү-аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлт, илрүүлсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хийсэн**

**ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

**Шалгалт хийх үндэслэл:** Үндэсний аудитын газрын бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Оросын Холбооны Улсын Тооцооны танхимын ажлын төлөвлөгөөний 3.3.20 дугаар заалт, 2006 оны 11 дүгээр сарын 21-нд Улаанбаатар хотноо болсон Монгол Улсын Үндэсний аудитын газрын Удирдлагын зөвлөл болон ОХУ-ын Тооцооны танхимын Коллегийн хамтарсан хуралдааны шийдвэр, Монгол Улсын Ерөнхий аудитор Л.Жавзмаа, ОХУ-ын Тооцооны танхимын дарга С.В.Степашин нарын баталсан Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн 2003-2005 оны санхүү-аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлт, илрүүлсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хийх шалгалтын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.

**Шалгалтын зорилт:** ОХУ-ын Тооцооны танхим болон ҮАГ-ын хамтарсан баг Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагаанд 2006 оны 5 дугаар сард хийсэн шалгалтаар илрүүлсэн төлбөр, зөрчлийг барагдуулах талаар хийсэн ажлыг шалгах.

**Шалгуур үзүүлэлт:** Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр, протокол /тэмдэглэл/, Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг болон Оросын Холбооны Улс, Монгол Улсын яам, холбогдох газрын баримт бичиг, санхүүгийн тайлан мэдээ, байгууллагын гэрээ, хэлцэл, санхүү, банкны бусад бичиг баримтууд.

**Шалгагдах байгууллага:** Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэг.

**Хамрагдах хугацаа:** 2006-2007 он

**Гүйцэтгэх хугацаа:** 2008 оны 5 дугаар сарын 12-ноос 5 дугаар сарын 30-ны өдөр хүртэл.

**Шалгалтын явцад тогтоосон нь:**

**1. Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн товч танилцуулга**

Монгол-Оросын “Улаанбаатар Төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэг (цаашид “УБТЗ” ХНН) ЗХУ, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрийн дагуу байгуулагдсан. (Цаашид 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээр гэх).

Монгол-Оросын “УБТЗ” ХНН нь Багануур, Шарын-Гол, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр, Дархан болон Хөтөлийн цемент шохойн үйлдвэр, Дарханы дулааны цахилгаан станц, Орос-Монголын хамтарсан уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет нэгдэл зэрэг Монгол Улсын 60 гаруй томоохон нүүрсний болон хүдрийн уурхай, дулааны цахилгаан станц, төмөрлөгийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд үйлчилдэг байна.

Өнөөдрийн байдлаар УБТЗ-ын нийт урт 1815 км бөгөөд станцуудад 350 гаруй км салбар болон туслах замтай байна.

Хувь нийлүүлэгчдийн зүгээс Хэлэлцээрийн үндсэн дээр Монголын талаас 1968 оны 7 дугаар сарын 20-ны өдөр, Зөвлөлтийн талаас 1968 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурагдсан “УБТЗ” ХНН-ийн Дүрэм батлагдан, өнөөг хүртэл мөрдөн ажиллаж байна.

1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн Хэлэлцээрт хамаарах 1999 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн протоколоор “УБТЗ” ХНН-ийн дүрмийн сан 3.648.312,12 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд Оросын талд 1.824.156,06 мянган төгрөг, Монголын талд 1.824.156,06 мянган төгрөг ногдож байна.

“УБТЗ” ХНН-ийн улсын бүртгэлийн дугаар 90190009041, 2006 оны 3 дугаар сарын 21-ний өдөр бүртгүүлсэн байна.

Нийгэмлэгийн байрлах газар-Монгол Улс, Улаанбаатар хот.

“УБТЗ” ХНН-ийн дэлгэрэнгүй мэдээлэл нь (“УБТЗ” ХНН-ийн үүсэл хөгжил, үйл ажиллагаа, нийгэмлэгийн “Дүрэм”-ийг тодорхойлсон Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр болон бусад бичиг баримт) 2006 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Монгол-Оросын “УБТЗ” ХНН-ийн 2003-2005 оны санхүү-аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайланд тусгагдсан байгаа болно. (вх.№ КМ-509/05-1)

Дээр дурьдсан тайлан нь Монгол-Оросын “УБТЗ” ХНН-ийн 2003-2005 оны санхүү-аж ахуйн үйл ажиллагаанд ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын газрын хамтарсан багийн бүрэлдэхүүнтэй хийгдсэн шалгалтын үр дүнг харуулсан болно.

Шалгалтын тайлан Монгол Улсын ҮАГ-ын Удирдлагын зөвлөл, ОХУ-ын Тооцооны танхимын Коллегийн хамтарсан хуралдаан болон Монгол Улсын Ерөнхий аудитор Л.Жавзмаагийн 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 83 дугаар тушаалаар батлагдсан болно. (2006 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн №41К (508) дугаар хамтарсан хуралдааны тэмдэглэл )

Шалгалтын дүнг Орос-Монголын Засгийн газар хоорондын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны комисст 2006 оны 7 дугаар сард мэдээлсэн.

## **2. “УБТЗ” ХНН-ийн удирдлага дахь Монгол Улс болон ОХУ-ын оролцоо, ХНН-ийн дүрмийн мөрдөлт**

“УБТЗ” ХНН-ийн хувь эзэмшигчид нь Монгол Улсын болон ОХУ-ын Засгийн газар юм. Хувь нийлүүлэгчийн эрхийг Монгол Улсын Засгийн газрын өмнөөс Зам, тээвэр, аялал жуулчлалын яам, ОХУ-ын өмнөөс Төмөр замын тээврийн агентлаг хэрэгжүүлдэг байна. (тус тус 50 хувь)

2006-2007 онд “УБТЗ” ХНН-ийн хувь нийлүүлэгчдийн Ерөнхий хорооны хуралдаан 9 удаа болсон бөгөөд 2006 онд 5, 2007 онд 4 удаа хуралдаж, дараахь асуудлыг хэлэлцжээ.

- “УБТЗ” ХНН-ийн 2005 оны тайлан балансыг шалгасан тухай нийгэмлэгийн Хянан шалгах хорооны дүгнэлт;
- “УБТЗ” ХНН-ийн 2005 оны үйлдвэрлэл-санхүүгийн үйл ажиллагааны тайланг баталж, тайлант оны үр дүнгээр гарсан ашгийн хуваарилалт;
- “УБТЗ” ХНН-ийн 2006 оны үйлдвэрлэл-аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;
- “УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
- Хянан шалгах комиссын гишүүдийн томилгоо.

Дээр дурдагдсан хугацаанд Нийгэмлэгийн Ерөнхий хорооны хуралдааныг 7 удаа хийж (2006 онд 4, 2007 онд 3 удаа) “УБТЗ” ХНН-ийн үйл ажиллагааны чухал асуудлыг хэлэлцсэн байна. Тухайлбал,

- “УБТЗ” ХНН-ийн дарга, түүний орлогч, СНББА-ны дарга нарын томилгоо;
- “УБТЗ” ХНН-ийн 2005 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө ба ашиглалтын үндсэн үзүүлэлтийн хэрэгжилтийн үр дүн;
- “УБТЗ” ХНН-ийн 2006, 2007 оны ачаа тээврийн төлөвлөгөөг батлах;
- Дамжин өнгөрөх тээврийн тарифын талаар;
- Шилэн кабелийн сүлжээний ашиглалтын үр дүн;
- “УБТЗ” ХНН-т өмнөх оноос ирсэн ашиглах боломжгүй хөрөнгийн борлуулалт ба хасагдуулалт;
- “УБТЗ” ХНН-ийн санхүүгийн тайланд хийсэн аудиторын дүгнэлт;
- Ачаа тээврийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- УБТЗ-ын техникийн шинэчлэлийн талаар;
- Говь, Дорнод Монголын бүс нутаг дахь ашигт малтмалын томоохон олборлолтын тээвэрлэлтийн хангамжид “УБТЗ” ХНН-ийн оролцоо;
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний явц;
- Монгол-Оросын “УБТЗ” ХНН-ийн хугацаа хэтэрсэн өр, түүний барагдуулалтын талаар;
- Ашиглалтын үзүүлэлтийг сайжруулах ажлын төлөвлөгөөний талаар;
- Шинэ төмөр замын зангилааг барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах санхүүжилтэд “УБТЗ” ХНН-ийн оролцоо;
- Ханшийн тэгшитгэлийн үе шатны бичилтийн талаар;
- Өр төлбөрийг дахин ангилах талаар;
- Шилэн кабелийн холболттой тоног төхөөрөмжийг худалдан авах;
- Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй авах арга хэмжээний төлөвлөгөөний талаар;

- Зүтгүүрийн аж ахуйн өнөөгийн төлөв ба галт тэрэгний техникийн шинэчлэл;
- Орон сууцны хувьчлал болон бусад асуудлууд.

Гэвч Ерөнхий хорооны хуралдаанаар Нийгэмлэгийн 2007 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, 2006, 2007 оны үр дүнгээрх ноогдол ашгийн хуваарилалт, санхүүгийн тайлан тэнцлийг хэлэлцэж батлаагүй нь “УБТЗ” ХНН-ийн Дүрмийн 10 дугаар заалтыг зөрчиж байна.

Нийгэмлэгийн Хянан шалгах комисс тогтоосон хугацаанд 2006, 2007 оны тайлан тэнцэл, ноогдол ашгийн хуваарилалтад үнэлэлт, дүгнэлт өгөөгүй нь “УБТЗ” ХНН-ийн Дүрмийн 30 дугаар заалтыг зөрчсөн байна. (Цаашид Дүгнэлт гэх)

2006 оны дүгнэлтийг 2008 оны 4 дүгээр сард бэлтгэсэн, 2007 оны үр дүнгийн талаарх дүгнэлтийг 2008 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар гаргаагүй байна.

### **3. Монгол-Оросын “УБТЗ” ХНН-ийн 2006-2007 оны үйл ажиллагааны техник-эдийн засаг болон санхүүгийн үндсэн үзүүлэлт**

2006-2007 онуудад “УБТЗ” ХНН-ийн ажлын үзүүлэлтүүд харьцангуй буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- дурьдагдсан онуудад ОХУ-аас БНХАУ-руу төмөр замаар дамжин өнгөрөх нилээд ашигтай ачаа тээвэрлэлтийн хэмжээ багассан (нефть бүтээгдэхүүн, мод гэх мэт);
- дотоодын ачаа тээвэрлэлтэд эдийн засгийн үндэслэлгүй үнийн бодлого мөрдөгдсөн;
- түлш болон бусад нефтийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбогдож ачаа тээвэрлэлтийн өөрийн өртөг өссөн.

#### **3.1. Эдийн засгийн үзүүлэлтүүд**

“УБТЗ” ХНН-ийн 2006-2007 оны эдийн засгийн үзүүлэлтүүдийг дараахь хүснэгтэд үзүүлбэл: (2005 оны үзүүлэлттэй харьцуулав)

| Үзүүлэлт  | <i>/мянган төгрөг, хувиар/</i> |             |             |
|---|--------------------------------|-------------|-------------|
|   | 2005 он                        | 2006 он     | 2007 он     |
| Нийт хөрөнгө  | 212.080.832                    | 219.007.434 | 241.216.233 |
| Цэвэр ашиг (тайлангаар)   | 4.030.988                      | 4.288.727   | 2.611.460   |
| Эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон бусад тусгай санд ашгаас хуваарилсан хэмжээ  | 2.495.988                      | 2.150.222   | 1.309.254   |
| Ноогдол ашигт хуваарилсан   | 1.535.000                      | 2.138.505   | 1.302.206   |
| Нийт хөрөнгийг өмнөх онтой харьцуулсан харьцаа                                    | 126,91 %                       | 103,27 %    | 110,14 %    |
| Цэвэр ашгийг өмнөх онтой харьцуулсан харьцаа                                      | 170,98 %                       | 106,39 %    | 60,89 %     |
| Ашигт ажиллагааны түвшин (цэвэр ашгийг нийт хөрөнгийн эхний үлдэгдэлд харьцуулах) | 2,41 %                         | 2,02 %      | 1,19 %      |
| Цэвэр ашгийн дүнд эзлэх ноогдол ашгийн хувь                                       | 38,08 %                        | 49,86 %     | 49,87 %     |

2007 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээс үзэхэд цэвэр ашгийн хэмжээ 2006 онтой харьцуулахад 39,1 хувь буюу 2,6 тэрбум төгрөгөөр буурсан байна. (Монголбанкны ам.долларын ханшаар 2,3 сая ам.доллар). Түүнчлэн шалгалтаас үзэхэд, замын балансад тусгагдаагүй гадаад валютаарх урт хугацаат өрийн ханшийн зөрүүний алдагдлын хэмжээ 30,6 тэрбум төгрөгт хүрч байна.

Цэвэр ашиг 2006 оны тайланд 2005 оны тайлангаас өссөн (6.4 хувиар) нь “УБТЗ” ХНН-ээс зарим дотоод ачаа тээвэрлэлтийн тарифыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбоотой болно. (химийн бордоо, хар төмөр, мод тээвэр, зэс молибдены баяжмал, машин механизм)

Урт хугацаат өр төлбөрийн хэмжээ өссөнтэй холбоотойгоор 2007 оны нийт хөрөнгийн дүн өссөн байна. (байгууллагын хөрөнгийн хэмжээ буурсан)

Ашигт ажиллагааны түвшинг 2005 онтой харьцуулахад 2006 онд 16.2 хувь, 2007 онд 41.1 хувиар тус тус буурсан байна.

### 3.2. Санхүүгийн үр дүн (үйл ажиллагааны төрлөөр)

*/мянган төгрөг, хувиар/*

| Үйл ажиллагааны төрөл                                  | 2005 он          | 2006 он          | 2007 он          |
|--|------------------|------------------|------------------|
| Тээвэрлэлт   | 9.236.968        | 5.734.653        | 6.405.131        |
| Үйлдвэрийн бүтээгдэхүүн                                | -52.430          | -246.510         | -570.401         |
| Үйлдвэрийн бус аж ахуй                                 | 6.928.337        | 7.209.273        | 7.575.981        |
| Барилга, угсралтын ажлууд                              | 57.029           | -78.657          | -50.111          |
| Орон сууц, нийгэм хангамжийн аж ахуй                   | -3.085.623       | -2.746.268       | -2.508.332       |
| Түлш, бараа материалын зарцуулалт                      | 253.117          | 192.301          | 425.334          |
| Эрүүлийг хамгаалах болон соёл, боловсролын байгууллага | -4.850.946       | -5.249.926       | -5.601.944       |
| Бусад үйл ажиллагаа                                    | -4.455.464       | -526.139         | -3.064.198       |
| <b>Тайлангаар гарсан санхүүгийн үр дүн – Нийт дүн</b>  | <b>4.030.988</b> | <b>4.288.727</b> | <b>2.611.460</b> |

Хүснэгтээс харахад ашгийн хэмжээнд тээвэрлэлт болон үйлдвэрлэлийн бус аж ахуй нөлөөлж байгаа бөгөөд алдагдлын зонхилох хувийг Эрүүлийг хамгаалах болон соёл, боловсролын байгууллага, орон сууц, нийгэм хангамжийн салбар эзэлж байна.

Бусад үйл ажиллагааны алдагдалд төгрөгт ногдох гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал нөлөөлжээ.

Нийгэмлэгийн 2006-2007 оны зардлын бүтцийг авч үзэхэд түлш (2005 онд 31,3 хувь байснаас 2007 онд 36,1 хувь хүртэл), хөдөлмөрийн хөлс (16,5-21,5 хувь хүртэл), материалын зардал(6,2-11,9 хувь хүртэл)-ын эзлэх хувь өссөн байна.

### 3.3. Үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд

Нийгэмлэгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа дараахь үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлэгддэг.

| Үзүүлэлт            | Хэмжих нэгж | 2005 он  | 2006 он  | 2007 он  | 2006/05 % | 2007/06 % |
|---------------------|-------------|----------|----------|----------|-----------|-----------|
| Тээвэрлэсэн ачаа    | мян. тн     | 15.572,5 | 14.793,2 | 14.072,6 | 95,0      | 95,1      |
| Тээвэрлэсэн зорчигч | мян. хүн    | 4.238,3  | 4.329,9  | 4.482,4  | 102,2     | 103,5     |
| Ачаа эргэлт         | сая.тн-км   | 9.929,1  | 9.218,5  | 8.360,6  | 92,8      | 90,7      |

|                            |                |           |           |           |       |       |
|----------------------------|----------------|-----------|-----------|-----------|-------|-------|
| Зорчигч эргэлт             | сая.хүн-<br>км | 1.241,6   | 1.288,5   | 1406,4    | 103,8 | 109,2 |
| Шилжүүлсэн тонн-км         | сая.төг/км     | 11.170,7  | 10.507,0  | 9.767,0   | 94,1  | 93,0  |
| Нийт зарцуулалт            | сая.төг        | 181.304,8 | 176.741,3 | 166.923,1 | 97,5  | 94,4  |
| 1 тонн-км-ийн өөрийн өртөг | төгрөг         | 16,23     | 16,82     | 17,09     | 103,6 | 101,6 |

2006-2007 онуудад тээвэрлэсэн ачааны хэмжээ буурсан байдал ажиглагдсан ба 2006 онд 5 хувь, 2007 онд 4,9 хувь, ачаа эргэлт 2006 онд 7.2 хувь, 2007 онд 9.3 хувиар тус тус буурсан байна.

Дараахь үзүүлэлтээр ачаа тээвэрлэлтийн өөрчлөлтийн хэмжээ илэрхийлэгдэж байна.

*/сая тонн-км, сая хүн-км, хувиар/*

| Тээврийн төрөл              | 2005 он |        | 2006 он |        | 2007 он |        |
|-----------------------------|---------|--------|---------|--------|---------|--------|
|                             | Хэмжээ  | Хувь   | Хэмжээ  | Хувь   | Хэмжээ  | Хувь   |
| 1. Ачаа эргэлт              | 9.929,1 | 100,0% | 9.218,5 | 100,0% | 8.360,6 | 100,0% |
| 1.1. гаргалт                | 1.267,7 | 12,8%  | 1.509,5 | 16,4%  | 1.404,0 | 16,8%  |
| 1.2. орон нутаг             | 2.158,2 | 21,7%  | 2.203,9 | 23,9%  | 2.440,6 | 29,2%  |
| 1.3. оруулалт               | 522,0   | 5,3%   | 544,6   | 5,9%   | 660,6   | 7,9%   |
| 1.4. дамжин өнгөрөх тээвэр: | 5.981,2 | 60,2%  | 4.960,5 | 53,8%  | 3.855,4 | 46,1%  |
| БНХАУ-аас ОХУ-руу           | 399,6   | 4,0%   | 517,0   | 5,6%   | 586,7   | 7,0%   |
| ОХУ-аас БНХАУ-руу           | 5.581,6 | 56,2%  | 4.443,5 | 48,2%  | 3.268,7 | 39,1%  |
| 2. Зорчигч эргэлт           | 1.241,6 | 100,0% | 1.288,5 | 100,0% | 1.406,4 | 100,0% |
| 2.1. гаргалт                | 63,0    | 5,1%   | 69,0    | 5,4%   | 72,9    | 5,2%   |
| 2.2. орон нутаг             | 1.142,7 | 92,0%  | 1.180,9 | 91,6%  | 1.292,9 | 91,9%  |
| 2.3. оруулалт               | 24,7    | 2,0%   | 26,8    | 2,1%   | 29,1    | 2,1%   |
| 2.4. дамжин өнгөрөх тээвэр  | 11,2    | 0,9%   | 11,8    | 0,9%   | 11,5    | 0,8%   |

Нилээд ашигтай ачаа тээвэр (дамжин өнгөрөх тээвэр)-ийн нийт ачаа эргэлтэд ногдох хэмжээ 2005 онд 60.2 хувь байснаас 2007 онд 46.1 хувь хүртэл буурсан байна.

Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үр ашгийг харуулсан үзүүлэлтийг доорхи хүснэгтэд харуулбал:

| Үзүүлэлт   | Хэмжих нэгж | 2005 он  | 2006 он  | 2007 он | 2006/05 % | 2007/06 % |
|--|-------------|----------|----------|---------|-----------|-----------|
| Ачааны вагон эргэлт                              | цаг         | 74,4     | 73,0     | 102,2   | 98,1      | 140,0     |
| - цэвэр эргэлтийн хугацаа                        | цаг         | 23,62    | 22,72    | 19,73   | 96,2      | 86,8      |
| - тээвэрлэлтийн явцад вагоны зогссон хугацаа     | цаг         | 20,23    | 22,17    | 29,24   | 109,6     | 131,9     |
| - өртөө хооронд вагоны зогссон хугацаа           | цаг         | 5,88     | 6,02     | 4,82    | 102,4     | 80,1      |
| - техникийн үйл ажиллагаанд зогссон хугацаа      | цаг         | 24,68    | 22,07    | 48,36   | 89,4      | 219,1     |
| Динамик даац                                     | тонн        | 53,10    | 51,53    | 48,60   | 97,0      | 94,3      |
| Вагоны хоногийн дундаж гүйлт                     | км          | 354,31   | 344,95   | 218,03  | 97,4      | 63,2      |
| Хоосон гүйлтийг ачаатай гүйлтэд харьцуулсан хувь | %           | 69,39    | 58,53    | 48,07   | 84,3      | 82,1      |
| Вагоны хоногийн дундаж бүтээмж                   | т-км        | 11.107,3 | 11.213,2 | 7.155,7 | 101,0     | 63,8      |
| Зүтгүүрийн хоногийн дундаж гүйлт                 | км          | 508,6    | 555,9    | 557,3   | 109,3     | 100,3     |
| Зүтгүүрийн хоногийн дундаж                       | т-км        | 908,9    | 996,2    | 990,6   | 109,6     | 99,4      |

| Үзүүлэлт       | Хэмжих нэгж | 2005 он | 2006 он | 2007 он | 2006/05 % | 2007/06 % |
|----------------|-------------|---------|---------|---------|-----------|-----------|
| бүтээмж        |             |         |         |         |           |           |
| Техникийн хурд | км/цаг      | 46,51   | 46,17   | 47,05   | 99,3      | 101,9     |
| Хэсгийн хурд   | км/цаг      | 37,24   | 36,50   | 37,80   | 98,0      | 103,6     |

2005 онтой харьцуулахад 2006-2007 онд хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үр ашиг нилээд буурсан байгааг дээрх үзүүлэлтүүд нотолж байна.

Тээвэрлэлтийн болон техникийн үйл ажиллагаанд вагоны зогсох хугацаа нэмэгдсэнтэй холбоотойгоор ачааны вагон эргэлт 2005 онд 74,4 цаг байсан бол 2007 онд 102,2 цаг болж нэмэгдсэн байна.

Вагоны хоногийн дундаж гүйлт 2005 онд 354,31 км байсан бол 2007 онд 218,03 км болж буурсантай холбоотойгоор вагоны хоногийн дундаж бүтээмж 11.107,3 тонн/км-ээс 7.155,7 тонн/км хүртэл буурсан байна.

Хөдөлмөрийн бүтээмжийг дараахь хүснэгтэд үзүүлэв.

| Үзүүлэлт                      | Хэмжих нэгж | 2005 он     | 2006 он     | 2007 он     | 2006/05 % | 2007/06 % |
|-------------------------------|-------------|-------------|-------------|-------------|-----------|-----------|
| Орон тоо (нийт)               | Хүн         | 15.689      | 15.087      | 14.935      | 96,2      | 99,0      |
| - тээвэрлэлтээр (ашиглалтаар) | Хүн         | 8.975       | 9.051       | 9.021       | 100,8     | 99,7      |
| - бусад                       | Хүн         | 6.714       | 6.036       | 5.914       | 89,9      | 98,0      |
| Бүтээгдэхүүн хэрэгжилт        | мян.төг     | 259.980.832 | 250.570.898 | 246.049.101 | 96,4      | 98,2      |
| - тээвэрлэлтийн орлого        | мян.төг     | 190.541.777 | 182.475.981 | 173.328.    | 95,8      | 95,0      |
| - бусад                       | мян.төг     | 69.439.055  | 68.094.917  | 72.720.842  | 98,1      | 106,8     |
| Нийт хөдөлмөрийн бүтээмж      | мян.төг/хүн | 16.570,90   | 16.608,40   | 16.474,66   | 100,2     | 99,2      |
| - ачаа тээвэрлэлтээр          | мян.төг/хүн | 21.230,28   | 20.160,86   | 19.213,87   | 95,0      | 95,3      |
| - бусад                       | мян.төг/хүн | 10.342,43   | 11.281,46   | 12.296,39   | 109,1     | 109,0     |

Нийгэмлэгийн орон тоо 2006-2007 онд нийтдээ 4.8 хувиар, үүнээс 2006 онд 3.8 хувь, 2007 онд 1.0 хувиар тус тус буурсан байна. Үүний улмаас 2006-2007 онд хөдөлмөрийн бүтээмж 0.6 хувиар буурчээ.

### 3.4. «Улаанбаатар төмөр зам» ХНН-ийн 2006-2007 оны тарифын бодлого

Нийгэмлэгийн дүрмийн дагуу ачаа, зорчигч, тээш, шуудан тээвэрлэлтийн тариф тогтоох нь нийгэмлэгийн Ерөнхий хорооны үүрэгт багтдаг.

2006-2007 онд “УБТЗ” ХНН-ээс дотоодын ачаа тээвэрлэлтийн тарифыг боловсронгуй болгох, тарифын алдагдлыг бууруулах талаар нилээд шийдвэрийг гаргасан байна.

Ерөнхий хорооны 2005 оны 11 дүгээр сарын 16, 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн 2006 оны нэгдүгээр сарын 1-нээс дотоодын тээвэрт хайлуур жонш 1.29; химийн ачаа, бордоо, мод, машин механизм, арьс шир–1.2; зэсийн баяжмал, төмрийн хүдэр 1.3 хувийн нэмэгдүүлсэн коэффициентийг мөрдөх болжээ.

**Харин 2007 оны 5 дугаар сарын 1-нээс:**

- Төмрийн бус хүдэрт 15, химийн ачаа, бордоонд 82, хар металлд 42, мод 37, зэс-молибдены баяжмал 50, нефть, нефтийн бүтээгдэхүүнд 17, машин механизмд 65, хайлуур жонш, арьс шир, хүнсний ачаа, чулуун нүүрс, барилгын материал, ахуйн эд хогшил, жижиг бараа, чингэлэгт 20 хувь байхаар тус тус дотоодын тээврийн тарифыг нэмэгдүүлсэн байна;
- Замын даргад зорчигч тээврийн тарифыг тогтоох эрхийг олгожээ.

“УБТЗ” ХНН-ээс тарифын бодлогыг боловсронгуй болгох талаар нилээд арга хэмжээ авсан боловч мөрдөгдөж буй тарифын тээвэрлэлтийн бодит өөрийн өртгийг тооцоогүйгээс дотоодын тээвэр үйлчилгээний ашигт ажиллагааг хангаж чадахгүй байна.

“УБТЗ” ХНН-ийн 2006-2007 оны дотоодын ачаа тээвэрлэлтийн өөрийн өртөг болон орлогын үзүүлэлтийг доорхи хүснэгтэд харуулав.

| Тарифын төрөл         | 2006 он                                     |   |                              | 2007 он                                    |   |                              |
|-----------------------|---|---|------------------------------|--|---|------------------------------|
|                       | Ачааны төрлөөр өөрийн өртөг 1 тн-км /төгрөг | Ачааны орлогын түвшин төгрөгөөр 1 тн-км-т | Өөрийн өртгийг нөхөх хувь, % | Ачааны төрлөөр өөрийн өртөг 1 тн-км/төгрөг | Ачааны орлогын түвшин төгрөгөөр 1 тн-км-т | Өөрийн өртгийг нөхөх хувь, % |
| Химийн бордоо         | 16,5  | 10,0                                      | 60,6                         | 16,6                                       | 18,3                                      | 110,5                        |
| Хар металл            | 19,1  | 14,8                                      | 77,5                         | 19,2                                       | 23,1                                      | 120,2                        |
| Мод                   | 16,8  | 13,6                                      | 81,1                         | 16,9                                       | 19,3                                      | 114,2                        |
| Зэс-молибдены баяжмал | 18,2  | 16,9                                      | 92,7                         | 18,3                                       | 24,9                                      | 136,4                        |
| Төмрийн хүдэр         | 18,8  | 18,4                                      | 98,0                         | 18,8                                       | 23,2                                      | 123,1                        |
| Нефть                 | 19,6  | 17,8                                      | 91,0                         | 19,0                                       | 21,3                                      | 112,2                        |
| Хайлуур жонш          | 17,4  | 15,2                                      | 87,6                         | 17,4                                       | 15,5                                      | 89,0                         |
| Машин механизм        | 40,6  | 32,4                                      | 80,0                         | 40,6                                       | 40,6                                      | 99,9                         |
| Арьс шир              | 20,0  | 11,8                                      | 59,3                         | 19,5                                       | 9,4                                       | 48,4                         |
| Хүнсний ачаа          | 15,9  | 7,9                                       | 49,6                         | 16,0                                       | 8,3                                       | 51,9                         |
| Нүүрс                 | 18,4  | 8,9                                       | 48,6                         | 18,4                                       | 10,1                                      | 54,5                         |
| Барилгын ачаа         | 16,3  | 80,3                                      | 491,0                        | 16,4                                       | 10,2                                      | 62,5                         |
| Гэрийн эд хогшил      | 19,8  | 13,7                                      | 69,2                         | 19,9                                       | 12,7                                      | 63,8                         |
| Жижиг илгээмж         | 59,5  | 35,3                                      | 59,3                         | 21,3                                       | 20,3                                      | 95,0                         |
| Контейнерын илгээмж   | 19,8  | 13,3                                      | 67,4                         | 59,5                                       | 41,9                                      | 70,4                         |
| <b>Нийт</b>           | <b>15,6</b>                                 | <b>13,5</b>                               | <b>86,2</b>                  | <b>16,0</b>                                | <b>14,6</b>                               | <b>91,1</b>                  |

2006 онд дотоодын бүх төрлийн ачаа тээвэрлэлт (барилгын материалаас бусад) “УБТЗ” ХНН-ийн тухайн тээвэрт зарцуулж буй зардлыг нөхөж чадахгүй байсан.



2007 оны 5 дугаар сараас эхлэн дотоод ачаа тээвэрлэлтийн тариф өссөнтэй холбогдож зарим ачааны (химийн бордоо, хар төмөр, мод тээвэрлэлт, зэс молибдены баяжмал, төмрийн хүдэр, нефть) орлогын түвшин тэдгээрийн өөрийн өртгөөс илүү гарчээ. Гэхдээ ихэнх ачаа тээвэрлэлт одоог хүртэл алдагдалтай хэвээр байна. (нүүрс, арьс шир, хүнсний бараа гэх мэт)

Доорхи хүснэгтэд дамжин өнгөрөх тээврийн өөрийн өртөг болон орлогын түвшинг харуулсан болно.

| Ачааны нэр           | 2006 он                                     |   |                              | 2007 он                                     |   |                              |
|----------------------|---|---|------------------------------|---|---|------------------------------|
|                      | Ачааны төрлөөр өөрийн өртөг 1 тн-км /төгрөг | Ачааны орлогын түвшин төгрөгөөр 1 тн-км-т | Өөрийн өртгийг нөхөх хувь, % | Ачааны төрлөөр өөрийн өртөг 1 тн-км /төгрөг | Ачааны орлогын түвшин төгрөгөөр 1 тн-км-т | Өөрийн өртгийг нөхөх хувь, % |
| Түүхий нефть         | 14,70                                       | 25,72                                     | 175,02                       | 14,11                                       | 26,08                                     | 184,81                       |
| Нефтийн бүтээгдэхүүн | 14,70                                       | 26,25                                     | 178,58                       | 14,11                                       | 27,27                                     | 193,24                       |
| Барилгын ачаа        | 14,57                                       | 9,34                                      | 64,10                        | 17,40                                       | 9,53                                      | 54,77                        |
| Коксжих нүүрс        | 13,09                                       | 10,86                                     | 82,95                        | 12,60                                       | 11,20                                     | 88,85                        |
| Мод                  | 13,31                                       | 18,31                                     | 137,63                       | 12,37                                       | 18,77                                     | 151,71                       |
| Төмрийн хүдэр        | 13,94                                       | 15,65                                     | 112,31                       | 14,10                                       | 16,97                                     | 120,35                       |
| Өнгөт металл         | 13,94                                       | 21,76                                     | 156,12                       | 14,10                                       | 16,80                                     | 119,20                       |
| Химийн ачаа          | 13,78                                       | 14,00                                     | 101,61                       | 13,30                                       | 15,12                                     | 113,66                       |
| Химийн бордоо        | 11,26                                       | 17,52                                     | 155,64                       | 10,40                                       | 15,99                                     | 153,82                       |
| Хар металл           | 13,94                                       | 14,20                                     | 101,91                       | 14,10                                       | 9,36                                      | 66,42                        |
| Бусад ачаа           | 13,92                                       | 11,20                                     | 80,43                        | 14,66                                       | 13,70                                     | 93,39                        |
| Ачаатай чингэлэг     | 20,90                                       | 11,67                                     | 55,87                        | 23,25                                       | 20,01                                     | 86,07                        |
| <b>НИЙТ</b>          | <b>13,48</b>                                | <b>20,45</b>                              | <b>151,69</b>                | <b>12,72</b>                                | <b>18,19</b>                              | <b>142,97</b>                |

2007 онд дамжин өнгөрөх ачааны төрлөөс нефтийн бүтээгдэхүүн (184,8 хувь), химийн бордоо (153,8 хувь), мод (151,7 хувь) хамгийн их буюу орлогоороо зарлагыг нөхөх тээвэрлэлтийн төрөлд тооцогдсон байна.

2007 онд Монгол Улсад тонн-километрт ногдох төмөр замын ачаа тээвэрлэлтийн тарифын дундаж үнэлгээ 0,012 ам.доллар байхад ОХУ-д 0,034 ам.доллар, БНХАУ-д 0,038 ам.доллар байна.

Нийгэмлэгийн хувьд орон нутгийн зорчигч тээвэрлэлт алдагдалтай байдаг. 2006 онд орлогоороо зардлаа нөхөх хувь 50,4, 2007 онд 64,8 хувь тус тус байна.

Дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн орлогоор дотоодын зорчигч тээвэрлэлтийн алдагдлыг нөхдөг бөгөөд 2007 оноос эхлэн олон улсын зорчигч тээврийн орлогоор алдагдлын зарим хэсгийг нөхөж байна.

Зорчигч тээврийн өөрийн өртөг болон орлогын үзүүлэлтийг дараахь хүснэгтэд харуулав.

| Тээвэрлэлтий | 2006 он | 2007 он |
|--------------|---------|---------|
|--------------|---------|---------|

| н төрлөөр             | Ачааны төрлөөр өөрийн өртөг 1 тн-км /төгрөг | Ачааны орлогын түвшин төгрөгөөр 1 тн-км-т | Өөрийн өртгийг нөхөх хувь, % | Ачааны төрлөөр өөрийн өртөг 1 тн-км /төгрөг | Ачааны орлогын түвшин төгрөгөөр 1 тн-км-т | Өөрийн өртгийг нөхөх хувь, % |
|-----------------------|---|---|------------------------------|---|---|------------------------------|
| Олон улсын тээвэрлэлт | 43,98                                       | 42,00                                     | 95,51                        | 43,91                                       | 54,80                                     | 124,80                       |
| Дотоод тээвэрлэлт     | 22,59                                       | 11,38                                     | 50,39                        | 22,56                                       | 14,62                                     | 64,80                        |
| Нийт                  | <b>24,38</b>                                | <b>13,94</b>                              | <b>57,18</b>                 | <b>24,29</b>                                | <b>17,97</b>                              | <b>73,98</b>                 |

Ачаа тээвэрлэлтийн санхүүгийн үр дүнг дараахь үзүүлэлтээр тодорхойлж болно.

*/мянган төгрөг/*

| Үйлчилгээний төрөл   | 2005 он     | 2006 он     | 2007 он     |
|--|-------------|-------------|-------------|
| <b>1. Дотоодын зорчигч тээвэр</b>                                  |             |             |             |
| Орлого   | 12.207.060  | 13.443.344  | 17.296.853  |
| Зарлага  | 26.589.996  | 26.683.184  | 26.693.669  |
| Алдагдал   | -14.382.936 | -13.239.840 | -9.396.816  |
| Орлогоор зардлаа нөхсөн хувь                                       | 45,9 %      | 50,4 %      | 64,8 %      |
| <b>2. Дотоодын ачаа тээвэрлэлт (чулуун нүүрсийг тооцохгүйгээр)</b> |             |             |             |
| Орлого   | 35.898.248  | 46.635.803  | 61.091.885  |
| Зарлага  | 48.276.445  | 56.212.582  | 62.301.938  |
| Алдагдал   | -12.378.197 | -9.576.779  | -1.210.053  |
| Орлогоор зардлаа нөхсөн хувь                                       | 74,4 %      | 83,0 %      | 98,1 %      |
| <b>3. Дотоодын ачаа тээвэрлэлт (чулуун нүүрс)</b>                  |             |             |             |
| Орлого   | 8.910.310   | 10.697.541  | 12.232.503  |
| Зарлага  | 21.975.044  | 20.926.461  | 21.405.307. |
| Алдагдал   | -13.064.734 | -10.228.920 | -9.172.804  |
| Орлогоор зардлаа нөхсөн хувь                                       | 40,2 %      | 51,1 %      | 57,2 %      |
| <b>4. Дамжин өнгөрөх ачаа тээвэр</b>                               |             |             |             |
| Орлого   | 124.212.744 | 101.450.230 | 70.128.627  |
| Зарлага  | 78.659.899  | 66.871.373  | 49.051.926  |
| Алдагдал   | 45.552.845  | 34.578.857  | 21.076.701  |
| Орлогоор зардлаа нөхсөн хувь                                       | 157,9 %     | 151,7 %     | 143,0 %     |

#### **4. Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн 2006-2007 оны үйл ажиллагаанаас Оросын Холбооны Улс болон Монгол Улсын Засгийн газарт ногдож буй хөрөнгийн хэмжээ**

##### **4.1. 2006 оны үр дүнгээр хуваарилсан ногдол ашиг**

Нийгэмлэгийн санхүү-аж ахуйн үйл ажиллагааны тайлангаар цэвэр ашгийн хэмжээ 4.288.727 мянган төгрөг болсон байна.

2006 оны ашгийг дараахь байдлаар хуваарилжээ:

- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн санд 2.150.222 мянган төгрөг;
- Ногдол ашигт– 2.138.505 мянган төгрөг (тал тус бүрт 1.069.252,5 мянган төгрөг).

2006 оны ашгаас Монголын талд ногдол ашиг болгож Төрийн сангийн дансанд 1.069.252,5 мянган төгрөг, үүнээс 2006 оны 3 дугаар сарын 29-нд–118.750,0 мянган төгрөг, 6 дугаар сарын 30-нд–318.500,0 мянган төгрөг, 10 дугаар сарын 17-нд 478.500,0 мянган төгрөг, 12 дугаар сарын 29-нд 153.502,5 мянган төгрөгийг тус тус шилжүүлжээ. Мөн 2005 оны ногдол ашгийн өрийг барагдуулахад 2006 оны 3 дугаар сарын 29-нд Монголын талд 27.592,42 мянган төгрөгийг нөхөн төлсөн байна. 2006 онд ногдол ашигт төлсөн дүн 1.096.844,9 мянган төгрөг болсон байна. 2005 оны ногдол ашгийн өрийг барагдуулахад 2006 онд Оросын талд нийт 1.083.990,0 мянган төгрөг буюу 927,0 мянган ам.долларыг төлсөн байна.

Уг хөрөнгийг ОХУ-ын Сангийн яамны Внешэкономбанк дахь №47422840200005340001 дугаар дансанд шилжүүлжээ. Үүнээс 2006 оны 3 дугаар сарын 29-нд 110,0 мянган ам.доллар, 2006 оны 6 дугаар сарын 30-нд 275,0 мянган ам.доллар, 2006 оны 9 дүгээр сарын 29-нд 410,0 мянган ам.доллар, 2006 оны 12 дугаар сарын 29-нд 132,0 мянган ам.долларыг тус тус шилжүүлжээ.

2005 оны ногдол ашгийн өрийн дутуу төлөлт 61,9 мянган төгрөг байна.

#### **4.2. 2007 оны үр дүнгээр хуваарилсан ногдол ашиг**

Нийгэмлэгийн 2007 оны санхүү-аж ахуйн үйл ажиллагааны тайлангаар цэвэр ашгийн хэмжээ 2.611.460 мянган төгрөг байна.

2007 оны уг ашгийг дараахь байдлаар хуваарилсан байна:

- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн санд 1.309.254 мянган төгрөг;
- Ногдол ашгийн хуваарилалт 1.302.206 мянган төгрөг (тал тус бүрт 651.103 мянган төгрөг).

2007 оны ногдол ашгаас Монголын талд 76.890,0 мянган төгрөгийг 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Төрийн сангийн дансанд төлсөн байна.

Ногдол ашгийн дутуу төлөлт 574.213,0 мянган төгрөг байна.

2007 оны ногдол ашгаас Оросын талд 76.890,0 мянган төгрөг буюу 66,0 мянган ам.долларыг төлсөн бөгөөд 2006 оны 3 дугаар сарын 29-ний өдөр ОХУ-ын Сангийн яамны Внешэкономбанк дахь №47422840200005340001 дугаар дансанд шилжүүлсэн байна.

2005 оны ногдол ашгийн өрийн төлөлттэй харьцуулахад 2007 оны ногдол ашгийн дутуу төлөлт 574.274,96 мянган төгрөг байна.

Нийгэмлэгийн Ерөнхий хорооны 2007 оны 4 дүгээр сарын 11-14-ний өдрийн шийдвэрийн дагуу (протокол № 1, 4.3 дахь заалт) 2007 оны ногдол ашгийг оны үр дүнг тодорхойлсны дараа хуваарилахаар хойшлогдсон байна.

#### **5. 2006 оны шалгалтаар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар хийсэн ажил**

“УБТЗ” ХНН-ийн 2003-2005 оны санхүү-аж ахуйн үйл ажиллагаанд 2006 оны 6 дугаар сарын 2-нд хийсэн шалгалтаар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, зохион байгуулалтад дараах зөрчлийг илрүүлсэн байна. Үүнд:

- 2003-2005 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд байгууллагын гадаад валютаар авсан урт хугацаат зээлийн өрийг тайлан гаргах үеийн ханшаар тооцоогүй. (2005

оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Санхүүгийн тайланд 34.822.459,1 мянган төгрөгийн ханшийн зөрүүтэй байна);

- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүйгээс бүртгэлд бодит бусаар тусгагдсан;
- Авлага бууруулах талаар хангалттай ажиллаагүй;
- Агуулахад удаан хугацаагаар ашиглагдахгүй байгаа бараа материал үнэ бүхий зүйлсийн хэмжээ нэмэгдсэн;
- “УБТЗ” ХНН-ийн түрээсийн төлбөрийн урт хугацаат зээлийн хэмжээг тайлан тэнцэлд тооцоо нийлж баталгаажуулалгүйгээр тусгасан (Замын-Үүд өртөөний ачаа шилжүүлэн ачиж-буулгах байгууламжийг түрээслүүлэхэд)

Энэ удаагийн шалгалтаар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар “УБТЗ” ХНН дараах ажлыг хийж гүйцэтгэснийг тогтоолоо.

Ерөнхий хорооны 2007 оны 4 дүгээр сарын 11-14-ний өдрийн хуралдаанаар гадаад валютаар тооцсон зээлийн өрийн ханшийн зөрүүг бүртгэлд тусгах асуудлыг хэлэлцсэн байна.

Тооцоолоогүй ханшийн зөрүүний өглөгийг үе шаттайгаар бүртгэлд тусгах, үүний зэрэгцээ төлсөн хэмжээгээр байгууллагын үндсэн өрийг хэсэгчлэн бууруулах шийдвэр гаргасан байна.

Ерөнхий Хорооноос 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тооцоолсон ханшийн зөрүү бүгд 28,9 тэрбум төгрөгийг 2007-2025 онд барагдуулах хуваарийг баталжээ.

Хуваарийн дагуу 2007 онд байгууллагын тайлан тэнцэлд ханшийн зөрүүг 1.797,3 сая төгрөгөөр тохируулах бичилт хийхээс 2.120,0 сая төгрөгөөр тусгасан байна.

Ерөнхий хороо нь нийгэмлэгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, түүнийг үнэлэх арга, хэрэгжүүлэх хугацааг нэг бус удаа хэлэлцсэний дээр 2006 оны 7 дугаар сарын 3-5-ны өдрийн хуралдаанаар (Протокол №3) дээрх асуудлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө, дараалал, санхүүжилтийн саналыг дараагийн хуралдаанд оруулахыг Замын даргад үүрэг болгожээ.

2006 оны 12 дугаар сарын 1-3-ны хооронд хийгдсэн хуралдааны явцад (Протокол №4) өмнөх хуралдаанаар өгөгдсөн үүрэг хангалтгүй байна гэж үзжээ. Энэхүү хуралдаанаар үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг зайлшгүй хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд уг ажлыг хэрэгжүүлэх аргачлал, хугацаа, түүний бэлтгэл ажлын төлөвлөгөөг дараагийн хуралдаанаар оруулахыг Замын даргад үүрэг болгосон байна. (Үнэлгээний байгууллага болон өөрсдийн хүчээр)

Ерөнхий хорооны 2007 оны 4 дүгээр сарын 11-14-ний өдрийн хуралдаанаар дараахь асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “УБТЗ” ХНН-ийн 2007 оны 1 дүгээр сарын 1-нээрх нийт хөрөнгийн дахин үнэлгээг 2007 онд хийх;
- Олон улсын эрхтэй Үнэлгээний компанийг сонгон шалгаруулж, Ерөнхий хорооны дарга, түүний орлогчид мэдэгдэхийг Замын даргад үүрэг болгосон;
- Үнэлгээний компанийг сонгох эрхийг Ерөнхий хорооны дарга, түүний орлогчид өгөх;

- Үнэлгээний компаниас ирүүлсэн саналыг үндэслэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал, техникийн даалгаврыг тодорхойлохыг Замын даргад үүрэг болгосон (Ерөнхий хорооны дарга, түүний орлогчтой зөвшилцөх);

Өнөөг хүртэл дээрх шийдвэрүүд хэрэгжээгүй, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй байна.

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооноос хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах зайлшгүй шаардлагатай авч хэрэгжүүлэх арга хэмжээний шийдвэр гаргажээ.

2007 оны 4 дүгээр сарын 11-14-ний өдрийн хуралдааны хэлэлцэх асуудалд авлагыг бууруулахад авах арга хэмжээний талаар тусгагдсан ба нийгэмлэгээс авлага бууруулах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг хангалтгүй гэж үзэж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, үүрэгт ажлаас нь чөлөөлөх хүртэлх арга хэмжээ авч ажиллахыг Замын даргын үүрэг гүйцэтгэгчид даалгажээ.

Ерөнхий хорооны 2007 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанд бэлтгэх ажлын хүрээнд авлагын бүтэц, үүссэн нөхцөлийг нийгэмлэгийн харъяа газар, албад нэг бүрээр судалж, мөн “УБТЗ” ХНН-ийн Хуулийн албанаас авлагыг барагдуулах талаар хийж буй ажлыг хэлэлцсэн байна.

Уг хуралдаанаар Ерөнхий хорооноос замын даргад авлагыг барагдуулах асуудлаар өгсөн үүргийн хэрэгжилтийг хангалтгүй гэж үзэн, дараахь шийдвэрийг гаргажээ. Үүнд:

- Холбогдох ажлын хүрээнд эрх зүйн болон эдийн засгийн үндэслэлгүй гэрээ байгуулсан буруутай албан тушаалтныг илрүүлэх;
- Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах үр нөлөөтэй ажлыг тодорхойлох зорилгоор Замын удирдах албадын зөвлөгөөнийг зохион байгуулах;
- Урьдчилгаа төлбөргүйгээр тээврийн үйлчилгээ үзүүлэхийг таслан зогсоох.

2007 оны хоёрдугаар хагаст найдваргүй авлагын хасагдуулга хийж, хугацаа хэтэрсэн авлагыг төлүүлснээр үлдэгдлийг 2007 оны 8 дугаар сараас 2008 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд 2.1 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

Гэвч “УБТЗ” ХНН-ийн Замын-Үүд өртөөний ачаа шилжүүлэн ачиж-буулгах байгууламжийн түрээсийн төлбөрийн урт хугацаат зээлийн өрийг тайлан тэнцэлд үнэн зөв тусгах асуудал хэрэгжээгүй байна.

## **6. Монгол улс болон бусад улсын шүүх хяналтын байгууллагаар хугацаа хэтэрсэн өрийн шийдвэрлүүлэлт, албадан барагдуулалтын ажлын үр дүн**

“УБТЗ” ХНН-ийн 2006, 2007 оны тэнцэлд тусгагдсан авлагыг хүснэгтээр үзүүлбэл:

| Үзүүлэлт  | /мянган төгрөг/  |                  |
|---|------------------|------------------|
|   | 2006.12.31       | 2007.12.31       |
| Нийт авлага:  | 4.515.868        | 4.729.143        |
| Найдваргүй авлагын нөөцийн хасагдуулга  | -469.130         | -395.005         |
| <b>Балансаарх цэвэр авлагын дүн (Найдваргүй авлагын нөөцийн хасагдуулга хийж тооцсон)</b> | <b>4.046.738</b> | <b>4.334.138</b> |

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх 12 сараас дээш хугацаа бүхий насжилттай авлагын дүн 2.484.231 мянган төгрөг буюу нийт авлагын 55.0 хувийг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3.377.790 мянган төгрөг буюу 71.4 хувийг тус тус эзэлж байна.

12 сараас дээш хугацаатай насжилт бүхий нийт авлагын дүнд дийлэнх хэсгийг эзэлж буй авлагын 64.5 хувь нь 2005-2006 онд, 23.4 хувь нь 2003 онд үүссэн байна.

“УБТЗ” ХНН-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын 2006 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тайланд тус байгууллагаас хугацаа хэтэрсэн авлагыг албадан барагдуулах зорилтот ажил хангалттай түвшинд хийгдээгүйг дурьдсан.

2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх “УБТЗ” ХНН-д хугацаа хэтэрсэн өртэй томоохон аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүсийг дурьдвал:

| Байгууллагын нэр            | /мянган төгрөг/       |             |
|-----------------------------|-----------------------|-------------|
|                             | Авлага үүссэн хугацаа | Авлагын дүн |
| М-Тур ХХК                   | 2004                  | 4,432.0     |
| “Грэйнд Бэй” ХХК            | 2005                  | 10,104.0    |
| “Сартваахь” ХХК             | 2002                  | 9,343.0     |
| “Сева” ХХК                  | 2003                  | 4,946.0     |
| “Редбэргюнион”              | 2005                  | 72,288.0    |
| ООО “ТЕСС”                  | 2005                  | 815,500.0   |
| Б.Хараа /нярав/             | 2004                  | 19,702.0    |
| “Монгол петролиум” компани  | 2004                  | 13,900.0    |
| “Монгол петролиум” компани  | 2004                  | 27,800.0    |
| “Итгэлт хүлэг” компани      | 2004                  | 72,922.0    |
| “Шарын гол” нүүрсний уурхай | 2001                  | 5,443.0     |
| “Монголросцветмет” нэгдэл   | 2002                  | 58,263.0    |
| “Цагаан ноён” компани       | 2002                  | 5,999.0     |
| “Автор” компани             | 2004                  | 34,460.0    |
| “МД-транс” ХХК              | 2004                  | 480,404.0   |
| “Эксит транс” компани       | 2003                  | 38,174.0    |
| “Бридж оф скай” ХХК         | 2003                  | 15,320.0    |
| “Уолдтранс”                 | 2003                  | 213,578.0   |
| “Гарьд” ХХК                 | 1998                  | 113,160.0   |
| ТЗХЭГ                       | 2005                  | 435,194.0   |
| “Хөвсгөл далай” компани     | 2003                  | 4,823.0     |
| “СОМТ” компани              | 2001                  | 3,388.0     |

Өнгөрсөн хугацаанд “УБТЗ” ХНН-ээс хугацаа хэтэрсэн авлагатай байгууллагын өрийг албадан барагдуулах талаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал,

- Нийт 29 байгууллагын авлагатай холбоотой баримт материалыг шүүх хяналтын байгууллагад шилжүүлсэн. Дээрх ажлын үр дүнд “Гарьд” ХХК, “Цагаан ноён” компаний өрийг төлүүлэх, “Итгэлт хүлэг”, “Экситтранс”, “Бридж оф скай”, М-Тур ХХК, “Экситтранс”, “Уолдтранс” компаний өрийг төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан.
- 2007 онд “Грэйнд Бэй” ХХК, Шарын гол нүүрсний хэсэг, “Монголросцветмет” нэгдэл, “Автор”, “Хөвсгөл далай”, “СОМТ”, “Редбэргюнион” зэрэг аж ахуйн нэгжийн өрийг төлүүлжээ.
- “МД-транс” ХХК дампуурсан тухай зарласан, “Монгол петролиум” компанийг эрэн сурвалжлах ажиллагаа зогсоогдсон гэсэн шүүхийн шийдвэрийг үндэслэн авлагыг найдваргүй авлагын нөөцөөс хасчээ.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын хэрэг эрхлэх газар”-аас 2005 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 3 тоот гэрээний дагуу үндсэн хөрөнгө худалдан авах, их засварын ажилд зориулан хүүгүйгээр /эргэн төлсөн нөхцөлд/ олгосон

435.194,0 мянган төгрөгийн үлдэгдэл 336.271,0 мянган төгрөгийн өрийг “УБТЗ” ХНН-т төлүүлэх ажил хангалтгүй хийгдсэн байна. Уг гэрээг “УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооны 2004 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэрийн дагуу байгуулжээ.

Засгийн газрын агентлаг ТЗХЭГ 2006 онд 60,0 мянган ам.доллар, 2007 онд 60,0 мянган ам.доллар буюу 75,0 сая төгрөг, 2008 онд 60,0 ам.доллар буюу бүгд 150,5 сая төгрөгийг “УБТЗ” ХНН-т төлөх эргэн төлөлтийн хуваарьтай ч 2006-2007 онд хуваарийн дагуу төлбөр хийгдээгүй байна. Мөн 2007 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн түрээсийн №ТГ/04/007 дугаар гэрээний дагуу “УБТЗ” ХНН-т үзүүлсэн үйлчилгээний төлбөрт буюу 99.817,3 мянган төгрөгийн өрийг ТЗХЭГ-аас авах авлагын дүнд харилцан суутгал буюу хоорондын тооцооны хэлбэрээр хасалт хийжээ.

“УБТЗ” ХНН 2007 оноос авлагыг барагдуулах ажлыг идэвхтэй хийж эхэлсэн бөгөөд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгээр 2007 онд барагдуулсан хугацаа хэтэрсэн авлагын дүнг 2006 онтой харьцуулахад 11.4 дахин өсгөжээ. (17.701,0 мянган төгрөгөөс 201.508,0 мянган төгрөг болжээ.)

Мөн Замын даргын тушаалаар 2006-2007 онд найдваргүй авлагын нөөцөөс нийт 96.564,0 мянган төгрөгийн авлагын хасагдуулга хийсэн ба үүнээс 2006 онд 22.651,0 мянган төгрөгийн, 2007 онд 73.913,0 мянган төгрөгийн хасагдуулгыг тус тус хийжээ.

“УБТЗ” ХНН-т 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх томоохон өртэй байгууллагуудыг дурьдвал:

| Д.д | Байгууллага, иргэдийн нэр | Авлага үүссэн он | Авлагын дүн /мян.төг/ | Тайлбар  |
|-----|---------------------------|------------------|-----------------------|--|
| 1   | ООО “ТЕСС” /ОХУ/          | 2005             | 818,979               | Төмөр замын рельс нийлүүлэлтийн                  |
| 2   | Dankan Limited /БНХАУ/    | 2006             | 559,948               | Суудлын болон ачаа тээврийн вагоны дугуйн засвар |
| 3   | “ЛЧ” компани /Монгол/     | 2006             | 282,752               | Дизель түлшний нийлүүлэлтээс                     |
| 4   | “Чи Пи Эн” ХХК            | 2006             | 116,195               | Цементийн нийлүүлэлтээс                          |
| 5   | “МД-транс” ХХК            | 2003             | 495,149               | Транзит тээврийн хөлс                            |
| 6   | ТЗХЭГ                     | 2005             | 336,271               | Олгосон зээл /хүүгүй/                            |
| 7   | “Итгэлт хүлэг” компани    | 2004             | 272,446               | Дизель түлшний зээлүүлсэн.                       |
| 8   | “Уолдтранс” ХХК           | 2003             | 232,265               | Транзит тээврийн хөлс                            |
| 9   | “Гарьд” ХХК               | 1998             | 96,660                | Сэлбэг, хэрэгслийн нийлүүлтийн                   |
| 10  | Иргэн Д.Алимаа            | 2006             | 42,623                | Дутагдал, шамшигдал                              |
| 11  | “Эксит транс” компани     | 2003             | 41,285                | Транзит тээврийн хөлс                            |
| 12  | Иргэн Б.Хараа             | 2004             | 19,702                | МҮБЗ-ийн зүйлийн дутагдал,                       |
| 13  | “Бридж оф скай” ХХК       | 2003             | 16,661                | Транзит тээврийн хөлс                            |

2008 оны 1 дүгээр улиралд Dankan Limited /БНХАУ/, “ЛЧ” компани /Монгол/, “Чи Пи Эн” ХХК /Монгол/-иас авах өрийг төлүүлсэн байна.

#### **7. “УБТЗ” ХНН-ийн 2006 болон 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх зээлийн өрийн талаар**

“УБТЗ” ХНН-ийн 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх тайлан тэнцэлд тусгагдсан нийт зээлийн өрийн хэмжээ 94.212.553,0 мянган төгрөг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 132.865.660,0 мянган төгрөг байна. Үүнээс 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар богино хугацаат өрийн хэмжээ 42.966.108,0 мянган төгрөг, 2007

оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 54.001.235,0 мянган төгрөг байна. Банкны үндсэн зээл, хүүгийн өрийн үлдэгдэл 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 21.038.316,0 мянган төгрөг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5.182.568,0 мянган төгрөг байна.

Богино хугацаат зээлийн өрийн үлдэгдлийн бууралт нь Газпром (ОХУ) банкнаас авсан зээлээр зарим өр төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой байна.

“УБТЗ” ХНН-ийн нягтлан бодох бүртгэлээр урт хугацаат өр 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 51.246.445,0 мянган төгрөг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 78.864.425,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат өр, төлбөрийн бүтцэд дараахь зээл хамрагдаж байна.

- Дэлхийн банкнаас Монгол Улсын Засгийн газарт тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх урт хугацаат зээлийн хүрээнд Сангийн яамнаас “УБТЗ” ХНН-т 1999 онд олгосон 6.220.000,00 зээлжих тусгай эрх буюу 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1.323.414,0 мянган төгрөг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1.326.654,0 мянган төгрөг,
- Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт Төмөр замын тээврийг сэргээн сайжруулах урт хугацаат зээлийн хүрээнд Сангийн яамнаас “УБТЗ” ХНН-т 2000 онд 2 удаагийн төслийн зээл олгогдсон, нийт зээлийн хэмжээ 3.306.675.125,00 иений 23 жилийн хугацаатай жилийн 1,2 хувийн хүүтэй зээлийн үлдэгдэл нийгэмлэгийн балансаар 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 14.839.600,0 мянган төгрөг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 16.505.829,0 мянган төгрөг,
- 4.585.363.646,00 иений 25 жилийн хугацаатай, жилийн 2,8 хувийн хүүтэй зээлийн үлдэгдэл нийгэмлэгийн балансаар 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 22.037.481,0 мянган төгрөг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 24.348.033,0 мянган төгрөгөөр тус тус тайлагнасан байна.
- 2006 онд Худалдаа хөгжлийн банкнаас авсан 14 сарын хугацаатай жилийн 10 хувийн хүүтэй 5,0 сая ам.долларын зээлийн үлдэгдэл 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5.825.000,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 2007 онд уг зээлийг төлж барагдуулжээ.
- 2007 оны 3-4 дүгээр сард “УБТЗ” ХНН-ээс эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зээлийн бүтцийг сайжруулах зорилгоор “Газпром” банкнаас (ОХУ) авсан бүгд 24.030 сая ам.долларын (28.114.379,0 мянган төгрөг) бага хүүтэй зээлийг 5 жилийн хугацаанд 9.25, үлдэх хугацаанд 8.95 хувиар төлөхөөр авсан байна. Уг зээлийг авснаар Худалдаа хөгжлийн болон Голомт банкны жилийн 10 хувийн хүүтэй зээлийг төлжээ.

Түүнчлэн урт хугацаат өр төлбөрийн бүтцэд ОХУ-ын Төмөр замаар өнгөрөх зорчигч тээврийн тарифын өсөлттэй холбогдон гарсан зөрүүнд төлөх 1.348.580,0 мянган төгрөгийн өр бий болсон байна.

Мөн “УБТЗ” ХНН-ийн нягтлан бодох бүртгэлд Замын-Үүд дахь ачаа шилжүүлэн ачиж-буулгах байгууламжийг түрээсээр ашигласны урт хугацаат зээлийн өрийг тайлан тэнцэлд бодитой тусгаагүй байна. (2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 7.220.950,0 мянган төгрөг, 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 7.220.950,0 мянган төгрөг)

Үүнээс гадна 1999-2007 онд гадаад валютаар авсан зээлийн тайлант хугацааны үеийн ханшийн өөрчлөлтийн зөрүүг нийгэмлэгийн тайланд төгрөгөөр илэрхийлэн тооцож тусгаагүйгээс шалтгаалан өрийн үлдэгдэл бодитойгоор илэрхийлэгдээгүй байна. 2007 оны



12 дугаар сарын 31-ний байдлаар тайланд тусгагдаагүй ханшийн зөрүү 30.604.641,0 мянган төгрөг болсон байна.

## 8. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

“УБТЗ” ХНН-ийн үндсэн хөрөнгийн дүнг бүтцийн хувьд авч үзвэл дараахь байдалтай байна.

| Хөрөнгийн төрөл                                  | /мянган төгрөгөөр/ |                    |                    |
|--|--------------------|--------------------|--------------------|
|  | 2006.01.01         | 2007.01.01         | 2008.01.01         |
| <b>Барилга</b>                                   | 35,572,875         | 37,038,282         | 31,016,164         |
| <b>Машин механизм, тоног төхөөрөмж</b>           | 31,337,895         | 37,532,386         | 39,646,382         |
| <b>Байгууламж</b>                                | 38,402,962         | 42,055,649         | 44,454,024         |
| <b>Хэмжих, шалгах, туршилтын багаж төхөөрөмж</b> | 4,812,467          | 4,485,391          | 4,627,251          |
| <b>Тээврийн хэрэгсэл</b>                         | 77,991,809         | 84,387,051         | 107,237,433        |
| <b>Аж ахуйн эд хогшил</b>                        | 4,204,825          | 3,966,779          | 4,074,082          |
| <b>Бусад хөрөнгө</b>                             | 52,830             | 52,830             | 52,830             |
| <b>Дүн</b>                                       | <b>192,375,663</b> | <b>209,518,368</b> | <b>231,108,166</b> |

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооны гаргасан шийдвэрт үндэслэн 2006-2007 онд үндсэн хөрөнгийн хасалтыг хийсэн байна.

Нягтлан бодох бүртгэлд тайлагнаснаар 2006 онд тэнцлээс бүгд 5.094.158,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө буюу тэдгээрийн дотор 4.126.357,0 мянган төгрөгийн өртөг бүхий хувьчлагдсан орон сууц, 525.602,0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 12.139,0 мянган төгрөгийн байгууламж, 48.549,0 мянган төгрөгийн хэмжих багаж, төхөөрөмж, 286.039,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 95.472,0 мянган төгрөгийн эд хогшлыг хасчээ.

2007 онд бүгд 8.363.739,0 мянган төгрөгийн өртөг бүхий хувьчлагдсан орон сууцыг тэнцлээс хассан байна.

## 9. “УБТЗ” ХНН-ийн үл хөдлөх хөрөнгийн газар эзэмшлийн бүртгэл, баталгаажуулалтын талаар 2006-2007 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

“УБТЗ” ХНН-ийн 2003-2005 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайланд тус байгууллагын үл хөдлөх хөрөнгө Монгол улсад мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэл, кадастрын албаны бүртгэлд бүртгэгдээгүйг дурьдаж байсан.

Дээрх санамжийн дагуу “УБТЗ” ХНН-ээс төмөр замын эзэмшил газарт газар хуваарилалтыг зохион явуулах бэлтгэл ажлыг хийх, цаашид кадастрын бүртгэлд бүртгүүлэхэд нийт 804.901,7 мянган төгрөгийг зарцуулах гэрээг Монгол улсын “Геомастер” компанитай байгуулжээ.

“Геомастер” компаний гаргасан ажлын гүйцэтгэлийг 2006 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хүлээн зөвшөөрсөн актаар нийт гүйцэтгэвэл зохих ажлын үнийн дүнгийн 80,0 хувь болох 453.705,6 мянган төгрөгийг тус компанид төлжээ.

Шалгагдах үеийн байдлаар үлдсэн ажил иж бүрнээр хийгдэж дуусгавар болоогүй байна.

Замын даргын тушаалаар 1949 оны хэлэлцээрээр зөвшөөрөгдсөний дагуу замын зурвас газрыг “УБТЗ” ХНН хугацаагүй ашиглах эзэмшил газрыг тогтоох, түүнд үндэслэн эзэмшил газрыг кадастрын албанд танилцуулж бүртгүүлэх, баталгаажуулах зорилго бүхий

ажлын хэсгийг байгуулжээ. Ажлын хэсгээс 2007-2008 онд баримтад тулгуурлан эзэмшил газрын хилийг үнэн зөв тогтоох, хянан баталгаажуулалтыг хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан байна.

Шалгагдах үеийн байдлаар ажлын хэсгээс 4 удаагийн хуралдааныг зохион байгуулж харъяа газрын болон кадастрын албанд зохих хүсэлт, шаардлагаа уламжилжээ.

#### **10. Нийгэм хангамж, дэд бүтэц, орон сууц нийтийн аж ахуйд зарцуулагдаж буй зардлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар**

“УБТЗ” ХНН-ийн 2003-2005 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайланд нийгэмлэгийн нийгэм хангамж, дэд бүтэц, орон сууц нийтийн аж ахуйд ашиглагдаж буй үндсэн хөрөнгийн өртөг, тэдгээрийн ашиглалт, арчилгаанд зарцуулж буй зардал 2003-2005 онд төдийлөн буураагүйг тэмдэглэж байжээ. Хувьчлагдсан орон сууцны хамт өндөр үнэтэй түлш хэрэглэдэг дулааны төвийг нийгэмлэгийн балансаас шилжүүлээгүй байна.

Шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “УБТЗ” ХНН-ээс нийгэм хангамж, орон сууцны объектуудын ашиглалт, арчилгаанд зарцуулж буй татаас, хөрөнгийн зардлыг бууруулахаар 2006-2007 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг авч үзсэн.

Шалгалтаар нийгэм хангамжийн буюу эрүүл мэнд, боловсрол, соёл, орон сууцны аж ахуйн үйл ажиллагаанаас хүлээх алдагдал нийт алдагдлын дийлэнхи хэсгийг эзэлж байгаа нь тогтоогдож байна.

“УБТЗ” ХНН-ийн нийгэм хангамжийн дэд бүтэц, орон сууцны аж ахуйд олгосон хөрөнгийн 2006-2007 оны санхүүгийн үр дүн дараахь байдалтай байна.

|  | <i>/мянган төгрөг/</i> |              |              |
|--|------------------------|--------------|--------------|
| Нийгэм хангамжийн дэд бүтэц, орон сууц | 2005 он                | 2006 он      | 2007 он      |
| Орлого                                 | 5,078,229.0            | 5,126,204.0  | 5,472,862.0  |
| Зарлага                                | 13,014,798.0           | 13,122,398.0 | 13,583,138.0 |
| Нэмж олгосон хөрөнгө /татаас/          | -7,936,569.0           | -7,996,194.0 | -8,110,276.0 |
| Зарлагад татаасын эзлэх хувь           | 61.0                   | 60.9         | 59.7         |

Дээрх зориулалтаар 2006 онд олгосон татаасын хэмжээг өмнөх онтой харьцуулахад 0,8 хувиар буюу 2003-2006 онд хамгийн бага түвшинд байсан ба 2007 онд 1,4 хувиар өссөн байна.

“УБТЗ” ХНН-ийн орон сууцны аж ахуйд 2006-2007 оны зардал, олгосон татаас, ашиглалтын зардлыг 2005 онтой харьцуулсан судалгааг доорхи хүснэгтээр харуулав.

|                               | <i>/мянган төгрөг/</i> |              |              |
|-------------------------------|------------------------|--------------|--------------|
| ОСНАА-н байгууламж            | 2005 он                | 2006 он      | 2007 он      |
| Орлого                        | 3,809,448.0            | 3,636,414.0  | 3,823,594.0  |
| Зарлага                       | 6,895,111.0            | 6,382,682.0  | 6,331,926.0  |
| Нэмж олгосон хөрөнгө /татаас/ | -3,085,623.0           | -2,746,268.0 | -2,508,332.0 |
| Зарлагад татаасын эзлэх хувь  | 44.8                   | 43.0         | 39.6         |

Судалгаанаас харахад сүүлийн жилд “УБТЗ” ХНН-ээс орон сууцны аж ахуйд зарцуулж буй хөрөнгө буурч буй эерэг төлөв ажиглагдаж байна. Орон сууцны аж ахуйд 2006 онд олгосон татаасыг өмнөх онтой харьцуулахад 339.355,0 мянган төгрөг буюу 11,0 хувиар, 2007 онд 237.936,0 мянган төгрөг буюу 8,7 хувиар тус тус буурчээ.

2006-2007 онд нийгэм хангамжийн дэд бүтцэд дэмжлэг болгон өгсөн татаасын хэмжээг 2005 онтой зэрэгцүүлэн доорхи хүснэгтээр үзүүлэв.

*/мянган төгрөг/*

| Байгууллагын нэр                         | 2005 он            | 2006 он            | 2007 он            |
|--|--------------------|--------------------|--------------------|
| Дуу бүжгийн чуулга                       | 106,942.0          | 90,177.0           | 94,150.0           |
| Амралтын газар                           | 167,600.0          | 132,406.0          | 29,928.0           |
| Төмөр замын коллеж                       | 390,449.0          | 422,242.0          | 411,402.0          |
| Эмнэлгийн байгууллага, хүүхдийн цэцэрлэг | 3,972,356.0        | 4,432,403.0        | 4,823,558.0        |
| Клуб                                     | 61,307.0           | 61,526.0           | 61,760.0           |
| Хүүхдийн асрамж                          | 109,890.0          | 81,168.0           | 118,949.0          |
| Хүүхдийн зуслан /Хандгайт/               | 28,195.0           | 15,463.0           | 2,281.0            |
| Бусад                                    | 14,207.0           | 14,541.0           | 13,421.0           |
| ТЗДСургууль                              | -                  | -                  | 51,057.0           |
| <b>Дүн</b>                               | <b>4,850,946.0</b> | <b>5,249,926.0</b> | <b>5,601,944.0</b> |

“УБТЗ” ХНН-ээс нийгэм хангамжийн бусад байгууллагын зардлыг санхүүжүүлэхэд зориулан олгосон татаас 2006 онд 398.980,0 мянган төгрөг буюу нийт зардлын 8,2 хувиар, 2007 онд 352.018,0 мянган төгрөг буюу 6,7 хувиар өссөн байна. 2007 оны өсөлт нь төмөр замын ажилчдын цалинг нэмэгдүүлсэн, мөн ТЗДС-д оруулсан нэмэлт хөрөнгө оруулалттай холбоотой байна.

2006-2007 оны орон сууцны хувьчлалыг хийхдээ өмнөх онуудын адилаар түлшний зарцуулалт ихтэй уурын зуух, ЦТП-г “УБТЗ” ХНН-ийн балансаас шилжүүлээгүй байна. Орон нутгийн байгууллагад шилжүүлсэн орон сууцны фондын цахилгаан хангамжтай холбогдолтой “УБТЗ” ХНН-ийн алдагдал (халуун ус, халаалт нийлүүлэх, түгээх) 2006 онд 800.5 сая, 2007 онд 575.0 сая төгрөгт хүрчээ.

#### 11. 2006-2007 оны өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт

“УБТЗ” ХНН-ийн нягтлан бодох бүртгэлээр тайлагнасан агуулахад байгаа бараа, материал үнэ бүхий зүйлийн 2006-2007 оны үлдэгдэл дараахь байдалтай байна.

*/мянган төгрөг/*

| Нэр төрөл                 | 2006.01.01          | 2007.01.01          | 2008.01.01          |
|---------------------------|---------------------|---------------------|---------------------|
| Түүхий эд материал        | 22,298,525.0        | 30,156,786.0        | 32,273,066.0        |
| Бараа, бэлэн бүтээгдэхүүн | 1,498,651.0         | 1,778,543.0         | 2,279,247.0         |
| Хангамжийн материал       | 3,196,907.0         | 5,954,263.0         | 5,456,929.0         |
| <b>Дүн</b>                | <b>26,994,083.0</b> | <b>37,889,592.0</b> | <b>40,009,242.0</b> |

Сэлбэг, түүхий эд материал, бараа бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн материалын 2006 оны үлдэгдлийг 2005 онтой харьцуулахад 1.4 дахин, 2007 онд 1.5 дахин өссөн байна.

Нягтлан бодох бүртгэлээр хангамжийн албаны агуулахад тоологдсон удаан гүйлгээтэй, мөн гүйлгээгүй гэгдэх бараа материал, үнэ бүхий зүйлийн үлдэгдлийг 2006-2007 оны байдлаар харуулбал:

*/мянган төгрөг, нэр төрлийн тоо/*

| Нэр төрөл                       | 2006.01.01-ний үлдэгдэл                     | 2007.01.01-ний үлдэгдэл                     | 2008.01.01-ний үлдэгдэл                     |
|---------------------------------|---|---|---|
| Удаан гүйлгээтэй бараа материал | 158,521.0<br><i>/142 нэр төрөл/</i>         | 316,178.8<br><i>/125 нэр төрөл/</i>         | 271,361.0<br><i>/125 нэр төрөл/</i>         |
| Гүйлгээгүй бараа материал       | 76,837.1<br><i>/87 нэр төрөл/</i>           | 18,936.1<br><i>/53 нэр төрөл/</i>           | 18,697.2<br><i>/53 нэр төрөл/</i>           |
| <b>Бүгд</b>                     | <b>235,358.7<br/><i>/229 нэр төрөл/</i></b> | <b>335,114.9<br/><i>/178 нэр төрөл/</i></b> | <b>290,058.2<br/><i>/178 нэр төрөл/</i></b> |

2006 онд хийгдсэн тооллогын үр дүнгээс үзэхэд 2007 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаарх Хангамжийн албаны агуулах дах удаан гүйлгээтэй бараа материалын үлдэгдэл их хэмжээгээр өссөн (бараг 2 дахин), мөн 2006 оны эхэнд тайлагнагдсан бараа материалын үлдэгдэлд тооллогыг үнэн зөв хийж байгаагүйтэй холбоотой байна.

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн үлдэгдлийг харуулбал:

| <i>/мянган төгрөг/</i>             |                      |                   |                   |                   |
|------------------------------------|----------------------|-------------------|-------------------|-------------------|
| <b>Нэр төрөл</b>                   | <b>2005.01.01</b>    | <b>2006.01.01</b> | <b>2007.01.01</b> | <b>2008.01.01</b> |
| БҮТЭЗ-ийн дүн                      | 856,618.0            | 985,316.0         | 1,367,536.0       | 5,846,735.0       |
| Үүнээс: Удаан гүйлгээтэй БҮТЭЗүйлс | 5,519.0              | 9,571.0           | 14,761.0          | 48,903.0          |
| Гүйлгээгүй БҮТЭЗүйлс               | 4,502.0 /1999 оноос/ |                   |                   | 4,502.0           |

БҮТЭЗ-ийн их хэмжээний үлдэгдлийн шалтгаан бол удаан хугацаагаар бүртгэлтэй, цаг тухай бүрт бүртгэлээс хасч байгаагүйг илтгэж байна.

2006-2007 онд бараа, ажил, үйлчилгээг худалдан авахтай холбогдсон гэрээг байгуулахдаа Замын даргын 2005 оны 160 дугаар тушаалаар баталсан “Гэрээ байгуулах тухай” журмыг мөрдлөг болгон ажилласан байна. Уг журамд гүйцэтгэх ажлын дараалал, бүртгэл, хадгалалт, биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг тусгасан байна.

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооноос бараа материалыг худалдан авах бэлтгэн нийлүүлэгчийг сонгох журмыг боловсронгуй болгох, мөн сонгон шалгаруулалтыг хэрхэн явуулах асуудлаар зохих арга хэмжээг авчээ.

“УБТЗ” ХНН-ээс 2006-2007 онд байгуулсан гадаад худалдааны гэрээний дагуу валютаар төлсөн дүнг доорхи хүснэгтээр харуулав.

| <b>Он</b>   | <b>Гэрээний тоо</b> | <b>Валютын нэр</b> | <b>Гэрээний дүн</b> |
|-------------|---------------------|--------------------|---------------------|
| <b>2006</b> | 111                 | Ам.доллар          | 89,028.2            |
|             |                     | Евро               | 6,685.2             |
|             |                     | Рубль              | 128.0               |
|             |                     | Юань               | 539.4               |
| <b>2007</b> | 105                 | Ам.доллар          | 96,655.0            |
|             |                     | Евро               | 3,846.0             |
|             |                     | Рубль              | -                   |
|             |                     | Юань               | 589.0               |

Нягтлан бодох бүртгэлээр тайлагнагдсан импортын гэрээний санхүүжилтийн дүн 2005 онд 94.241.854,2 мянган төгрөг, 2006 онд 86.066.733,6 мянган төгрөг, 2007 онд 96.981.556,5 мянган төгрөг байна.

Шалгалтын явцад “УБТЗ” ХНН-ээс 2006-2007 онд гадаадын байгууллагуудтай байгуулсан гэрээний төлбөрийн нөхцөлийг судалж үзэхэд өмнөх жилүүдийн адил өндөр эрсдэлтэй гэрээ байгуулжээ.

Ихэнх гэрээ буюу 80,0 гаруй хувийг 50-иас 100 хүртэл хувийн урьдчилсан төлбөрийн нөхцөлтэйгээр байгуулсан байна. Тухайлбал,

- “УБТЗ” ХНН-ээс ОХУ-ын Сезон компанитай СП6М сумны цахилгаан дамжуулагч нийлүүлэх 02-06/07 дугаар бүхий 2007 оны 6 дугаар сарын 14-нд байгуулсан гэрээгээр урьдчилсан төлбөрт 80 хувийг, барааг ачуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсны дараа үлдэгдэл 20 хувийн төлбөрийг хийх нөхцөлтэй, гэрээний үйлчлэх хугацааг 2007 оны 9 дүгээр сарын 30 хүртэл тогтоосон байна. 2007 оны 10 дугаар

сарын 8-нд өмнө байгуулсан гэрээнд нэмэлт оруулан гэрээний үнийн дүнг 99.800,00 ам.доллараар тогтоон уг сардаа төлбөрийг шилжүүлсэн байна. Гэвч “Сезон” компани гэрээний нөхцөлийг зөрчиж, чанарын шаардлага хангахгүй ашиглах боломжгүй сэлбэгийг нийлүүлжээ. Гэрээгээр худалдан авагч нь нийлүүлснээс хойш 30 хоногийн дотор нийлүүлэгдсэн чанаргүй барааг солихыг шаардах эрхтэй байна. Мөн гэрээний 7.2 дахь хэсэгт зааснаар бэлтгэн нийлүүлэгч байгууллага нийлүүлсэн чанаргүй бараагаа зохих хугацаанд сольж чадаагүй хугацаа хэтрүүлсэн болон нийлүүлэгдээгүй бол тухайн барааны өртгийн 0.1 хувиар хугацаа хэтрүүлсэн өдөр бүр торгууль төлөх ба түүний дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байхаар зохицуулагдсан байна.

Шалгагдах үеийн байдлаар гэрээний нөхцөлийн дагуу ямар нэг ажил хийгдээгүй байна.

- “УБТЗ” ХНН ОХУ-ын ТЕСС компаниас 2005 оны 12 дугаар сарын 21-нд төмөр замын рейлс төмөр авахаар 2006 оны 1 дүгээр сарын 27 хүртэл байгуулсан 2.405.000 ам.долларын гэрээг сонгон шалгаруулалт явуулалгүйгээр зуучлагчаар дамжуулан хийсэн нь Замын даргын баталсан “Гэрээ байгуулах тухай” журмын 2.3 дах заалтыг зөрчиж бэлтгэн нийлүүлэгчийн найдвартай байдал, төлбөрийн чадварыг газар дээр нь судлан үзээгүй байна. 2005 оны 12 дугаар сард бэлтгэн нийлүүлэгчид бүгд 700,0 мянган ам.долларын урьдчилгаа төлбөр шилжүүлсэн боловч “ТЕСС” компани өнөөг хүртэл гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Шалгалтын явцад байгуулсан гэрээг түүвэрчилсэн байдлаар шалгахад “УБТЗ” ХНН өөрөө гэрээний үүрэг хариуцлагаа зөрчсөнөөс үргүй зардал гаргасан байна.

- “УБТЗ” ХНН-ээс Украин улсын Харьковпродмаш компанитай цахилгаан хөдөлгүүр, сумны даралт хэмжигч, бусад бараа материалыг худалдан авахаар 188.111 ам.долларын гэрээг 50 хувийн урьдчилсан төлбөрийн нөхцөлтэйгээр 2006 оны 5 дугаар сарын 31-нд байгуулжээ. Гэвч санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан зөвхөн 94.055,50 ам.долларын төлбөрийг шилжүүлсэн байна. Гэрээний холбогдох заалтыг ашиглан нэмэлт нөхцөлийг бүрдүүлж, зөвшилцөлд хүрч чадаагүйгээс бэлтгэн нийлүүлэгчээс зөвхөн 90.541,00 ам долларын үнэ бүхий бараа материалыг нийлүүлсэн бөгөөд зөрүү 3.514,5 ам.доллар авлага хэлбэрээр бүртгэгдсэн байна.
- “УБТЗ” ХНН-ээс Эстони улсын “Коломна Энержи ресурс” компанитай хөдлөх бүрэлдэхүүний тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг худалдан авах тухай 1.430.808 еврогийн үнэ бүхий МТЗ-1/2005-19 дугаартай гэрээг 2005 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр байгуулжээ. 2006 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний хугацааг 2006 оны 9 дүгээр сар хүртэл сунгажээ. “УБТЗ” ХНН-ийн санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас нийлүүлсэн бараа материалын үнийг цаг хугацаанд нь төлж чадаагүйгээс төлбөр хийх хугацаа хагас жилээр хэтэрсэн байна. “Коломна Энержи ресурс” компаниас гэрээний талуудын хүлээх хариуцлага хэсгийн 5-д заасны дагуу торгууль шаардсанаар “УБТЗ” ХНН-ээс 2006 оны 8 дугаар сарын 11-нд 192.767,10 еврогийн торгууль төлжээ.

“УБТЗ” ХНН-ийн Санхүүгийн хяналт, шалгалтын хэлтсээс харъяа газар, албадад хийсэн шалгалтаар нийт 444.476,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлсний дотор 92.236,0 мянган төгрөгийн үнэ бүхий зүйл, мөнгөн хөрөнгийн дутагдал шамшигдал, 36.000,0 мянган төгрөгийн дизелийн түлшний дутагдал гарч холбогдох эздийг шүүх хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Санхүүгийн хяналт, шалгалтын хэлтсээс 2007 онд төмөр замын харъяа нэгжид 71 удаагийн шалгалт хийж, нийт 222.988,0 мянган төгрөгийн зөрчил, түүний дотор 30.820,0 мянган төгрөгийн бараа материалын үнэ бүхий зүйлийн дутагдлыг илрүүлсэн байна.

## **12. 2006-2007 онд хийгдсэн “УБТЗ” ХНН-ийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн талаар**

“УБТЗ” ХНН 2006 оны 1 дүгээр сарын 1-нээс Ерөнхий хорооны 2005 оны 3 дугаар сард хуралдсан хуралдааны шийдвэрээр баталсан зохион байгуулалтын бүтцийг мөрдөж байна.

Ерөнхий хорооны 2006 оны 4 дүгээр сарын 24-25-ны өдрийн хуралдааны 2 дугаар протоколоор удирдах газрын бүтцэд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар шийдвэрлэсэн байна.

- Материал техникийн хангамж, худалдааны албыг татан буулгаж, Замын даргын нэгдүгээр орлогч даргын удирдлагад “Хангамжийн алба”, Хүний нөөц, нийгмийн асуудал эрхэлсэн орлогч даргын удирдлага дор “Нийгмийн хангамжийн алба”-ыг тус тус байгуулах;
- Хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан Замын орлогч даргын орон тоог цомхотгох;
- Замын туслах аж ахуй хариуцсан Замын даргын орлогчийг ажиллуулах.

Гэвч Ерөнхий хорооны хурлаар шийдвэрлэсэн бүтэц, зохион байгуулалтын зарим өөрчлөлтүүд бүрэн хийгдээгүй байна. Техникийн бодлогын алба, Туршин нэвтрүүлэх төв татан буугдсан ч Техникийн бодлого, төсөл боловсруулах төв болон Барилгын хяналтын хэлтэс байгуулагдаагүй байна.

Ерөнхий хорооны 2007 оны 7 дугаар сарын 5-7-ны өдрийн хуралдааны 2 дугаар шийдвэрээр Замын даргад 2007 оны 9 дүгээр сарын 1-ний дотор “УБТЗ” ХНН-ийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шинэчилсэн бүтцийг танилцуулахыг даалгасан ч энэхүү ажил хийгдээгүй байна.

“УБТЗ” ХНН-ийн 2003-2005 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд хийсэн шалгалтын 2006 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тайланд “... Удирдах газар сайтар боловсруулагдсан дүрмээр үйл ажиллагаагаа чиглүүлээгүй, мөн хяналт шалгалтын алба, мэргэжилтнүүд удирдлагын зорилтыг хангахуйцаар чиг үүргийг хүлээсэн зохион байгуулалтгүй” гэж тэмдэглэгдсэн байна.

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооны 2006 оны 7 дугаар сарын 3-наас 5-ны өдрийн шийдвэрээр Удирдах газрын дүрмийг баталж, хяналт шалгалтын албаны зохион байгуулалтыг сайжруулжээ.

## **13. Төмөр замын техникийн шинэчлэл, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын талаар**

2006 онд хийгдсэн Монгол Улсын УАГ, ОХУ-ын Тооцооны танхимын хамтарсан шалгалтаар Улаанбаатар төмөр замын техник, технологийн хуучралт, хангамжийн түвшин доогуур, сул хөгжсөн дэд бүтэцтэйгээс хөдөлгөөний дундаж хурд оросын төмөр замтай харьцуулахад 2 дахин бага байгааг онцолж байжээ.

2005 онд Замын даргын баталсан “Улаанбаатар төмөр замыг 2005-2021 онд хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө”-нд 2005-2008 онд тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөдлөх бүрэлдэхүүний засварын баазыг бэхжүүлэх ажлууд тусгагдсан байна. Төлөвлөгөөг тээвэрлэлтийн хэмжээг өсгөсөн тооцоонд суурилан боловсруулсан ба “УБТЗ” ХНН-ийн нийт хөрөнгө оруулалтыг 420.250,3 сая төгрөгөөр тооцжээ.

Замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний засварын баазыг хөгжүүлэх зорилттой уялдуулан дараахь чиглэлээр буюу замын аж ахуй (зам, засварын техникийн түвшинг

сайжруулах), ачаа тээврийн аж ахуй (шугамын нэвтрэх, тээвэрлэх чадвар, станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх), холбоо (дохиолол, мэдээллийн системийг хөгжүүлэх, харилцаа холбооны найдвартай байдлыг нэмэгдүүлэх), хөдлөх бүрэлдэхүүн (парк шинэчлэлт, засварын баазыг бэхжүүлэх)-ий ашиглалтын үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, хөрөнгийг шинэчлэн сайжруулах арга хэмжээ авахаар төлөвлөгдсөн байна.

“УБТЗ” ХНН-ийн санхүүгийн хангалттай нөөц, эх үүсвэрийн дутагдалтай байдлаас шалтгаалан замын дэд бүтцийг хөгжүүлэх, хөдлөх бүрэлдэхүүний засварын баазыг бэхжүүлэх ажлууд хийгдэхгүй байна.

“УБТЗ” ХНН нь замын нэвтрэх чадварыг сайжруулахад шаардлагатай төмөр зам, хөдлөх бүрэлдэхүүний хомсдол зэрэг бэрхшээлтэй тулгарч байна. Зүтгүүрийн парк нь өндөр түвшний элэгдэлд орсон, найдвартай ажиллагааны түвшин доогуур, хоцрогдсон засварын баазтай байна. Тухайлбал,

- 2008 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар ачаа тээвэрт ашиглаж байсан 79 зүтгүүрээс зөвхөн 25 зүтгүүр ашиглагдаж, 32 зүтгүүр засварын шаардлагаар сул зогсож байна. 10 жил хүртэл хугацаагаар ашигласан илчит тэрэгний тоо 7 буюу 8,8 хувь, 11-20 жилийнх 5 буюу 6,3 хувь, 20-30 жилийнх 67 буюу 84,9 хувийг эзэлж байна.
- Нийт 3000 ачааны вагон байгаагаас 2008-2010 онд ашиглалтын хугацаа дуусах 560 вагон байна. Нийт вагоны бүрэлдэхүүнд 10 хүртэл жил ашигласан 184 вагон буюу 7,0 хувь, 11-20 жилийнх 829 буюу 31 хувь, 21-30 жилийнх 928 буюу 35 хувь, 30-аас дээш жилийнх 704 буюу 27,0 хувь, нийт паркад 21 жилээс дээш хугацаагаар ашиглагдсан вагон 62,0 хувийг тус тус эзэлж байна.

Замын аж ахуйд учирч буй гол бэрхшээл нь замын хяналтын болон оношлогооны хэрэгсэл биет элэгдэл, техникийн хоцрогдолд орсон байна.

Замын ихэнхи хэсэгт хамарч буй техникийн найдвартай байдлын түвшин доогуур байгаа нь замын нийт эд ангиуд (зам төмөр, дэр мод, бэхэлгээ, бусад эд анги) ихээхэн хэмжээний элэгдэлд орсон байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээг 2005 онтой харьцуулахад 2006 онд (хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 51.169.891,0 мянган төгрөг) 2.5 дахин (30.977.118,0 мянган төгрөг), 2007 онд 1.7 дахин (20.518.074,0 мянган төгрөг) буурсан байна.

Их засварын зардлын хэмжээг 2005 онтой (33.090.525,0 мянган төгрөг) харьцуулахад 2006 онд 12.0 хувь буюу 3.960.638,0 мянган төгрөг, 2007 онд 22.0 хувь буюу 7.264.640,0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Замын их засварын ажлын хэмжээ хангалтгүй байгаа бөгөөд жилд 40-50 км-ийг хамарч байна.

Дээр дурьдсан байдлаас үзэхэд “УБТЗ” ХНН-ийн өмнө зөвхөн төмөр замын дэд бүтцийг боловсронгуй болгох, шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг эрэлхийлэхээс гадна ашиглагдаж буй үндсэн хөрөнгийн техникийн нөхцөлийг сайжруулах, замын нэвтрэх чадварыг дээшлүүлэх санхүүгийн нөөц шаардлагатай байна.

#### **Дүгнэлт:**

1. “УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хороо, Замын даргаас 2006 онд нягтлан бодох бүртгэл, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд гарч байсан зөрчил, дутагдлыг арилгахад хугацаа хэтэрсэн авлагыг албадан төлүүлэх ажлыг эрчимжүүлэх, орон сууц, нийтийн аж

ахуйд зарцуулагдаж буй хөрөнгийн зардлыг бууруулах, үнэ тарифын бодлого, тооцооллыг сайжруулах ажлуудыг авч хэрэгжүүлсэн байна.

Мөн ашиглалтад байгаа замын байгууламжийн газар эзэмших эрхийг кадастрын албаар баталгаажуулах, нийгэмлэгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийх асуудлыг шийдвэрлэхээр нэг бус удаа авч үзэж байжээ.

“УБТЗ” ХНН-ийн орон сууц, нийтийн аж ахуйд зарцуулагдаж буй хөрөнгийн зардлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээний үр дүнд нааштай өөрчлөлт гарч байна. Орон сууц, нийтийн аж ахуйд олгосон татаасын хэмжээг өмнөх онтой харьцуулахад 2006 онд 11.0 хувиар, 2007 онд 8.7 хувиар буурсан байна.

2. Хувь нийлүүлэгчдийн хамтарсан хуралдаан, “УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооноос Нийгэмлэгийн үйл ажиллагаатай холбогдсон чухал асуудлуудыг шийдвэрлэж байжээ.

Гэвч Хувь нийлүүлэгчдийн хамтарсан хуралдаанаар Нийгэмлэгийн 2007 оны үйлдвэрлэл-санхүүгийн төлөвлөгөө, 2006, 2007 оны тайлан баланс, ногдол ашгийн хуваарилалтыг хэлэлцэж батлаагүй нь “УБТЗ” ХНН-ийн дүрмийн 10 дахь заалт зөрчигдсөн байна.

Мөн дүрмийн 30-д заасны дагуу Шалган байцаах комиссоос тогтоосон хугацаанд “УБТЗ” ХНН-ийн 2006, 2007 оны тайлан тэнцэл, ашиг хуваарилалт, ажлын үр дүнг хэлэлцэн дүгнэлт /цаашид “Дүгнэлт” гэх/ гаргаагүй байна. Нийгэмлэгийн 2006 оны ажлын үр дүнг хэлэлцсэн дүгнэлтийг зөвхөн 2008 оны 4 дүгээр сард гаргаж байсан бөгөөд 2007 оны үр дүнгийн дүгнэлтийг 2008 оны 6 дугаар сарын 1-нд бэлтгэсэн ч албан ёсоор баталгаажуулаагүй байна.

3. “УБТЗ” ХНН-ийн 2006-2007 оны үйлдвэрлэл, санхүүгийн үндсэн үзүүлэлт буурсан нь юуны өмнө дараахь шалтгаантай холбоотой байна. Үүнд:

- ОХУ-аас БНХАУ-д гаргаж буй нефть бүтээгдэхүүн, мод зэрэг харьцангуй ашигтай ачааны тээвэрлэлтийн хэмжээ буурсан;
- Нийгэмлэгээс орон нутгийн тээвэрт хэрэглэгдэж буй эдийн засгийн алдагдалтай үнэ тарифын бодлогын мөрдөлт;
- Цахилгаан зүтгүүр ашигладаггүй, мөн түлш, бусад нефть бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор тээвэрлэлтийн өөрийн өртөг өссөн.

3.1. 2007 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр цэвэр ашиг 2.6 тэрбум төгрөг буюу 2006 онтой харьцуулахад 39.1 хувиар буурсан байна. Үүнээс гадна нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэлд тусгаагүй гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал 30.6 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Энэ нь нийгэмлэгийн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагаа өнгөрөгч хугацаанд алдагдалтай явж ирсэн гэж үзэхээр байна.

3.2. Урт хугацаат зээлийн өрийн өсөлтийн хэмжээнээс шалтгаалан 2007 онд балансын дүн өссөн ч үүнтэй зэрэгцэн эзэмшигчийн өмч буурчээ. Нийгэмлэгийн ашигт ажиллагааны түвшинг 2005 онтой харьцуулахад 2006 онд 16.2 хувиар, 2007 онд 41.1 хувиар буурчээ.

3.3. Нийгэмлэгийн 2006-2007 оны зардлын бүтцийг авч үзэхэд түлш (2005 онд 31,3 хувь байснаас 2007 онд 36,1 хувь хүртэл), хөдөлмөрийн хөлс (16,5-21,5 хувь хүртэл), материалын зардал(6,2-11,9 хувь хүртэл)-ын эзлэх хувь өссөн байна.



3.4. 2006-2007 онд дамжин өнгөрөх ачаа тээврийн хэмжээ буурч байгаа нь ажиглагдсан бөгөөд 2006 онд 5 хувь, 2007 онд 4.9 хувиар, ачаа эргэлт 2006 онд 7.2 хувиар, 2007 онд 9.3 хувиар буурсан байна.

Нийт ачаа эргэлтийн дүнд эзлэх харьцангуй ашигтай дамжин өнгөрч буй ачааны тээвэрлэлтийн хэмжээ 2007 онд 2005 оныхоос 60.2 хувиас 46.1 хүртэл хувиар буурчээ.

3.5. 2006-2007 онд хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт буюу ачааны вагоны эргэлтийг 2005 онтой харьцуулахад мэдэгдэхүйц буурсан байна.

Ачааны вагон эргэлт 2005 онд 74.4 цаг байсан бол 2007 онд 102.2 цаг болсон нь үндсэндээ ачааны вагоны барааг ачиж, буулгах болон техникийн үйчилгээний үеийн хугацаа уртассанаас шалтгаалж байна.

Ачааны вагоны хоногийн дундаж бүтээмж 11,107.3 тн/км-ээс 7,155.7 тн/км болж буурсан нь ачааны вагоны хоногийн дундаж гүйлт 2005 онд 354.31 км байсан бол 2007 онд 218.03 км хүртэл болж буурснаас шалтгаалжээ.

4. “УБТЗ” ХНН-ээс 2005-2007 онд дотооддоо ачаа, тээврийн үйлчилгээг үзүүлэх үеийн тарифын алдагдлыг бууруулах, ачаа тээврийн тарифын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх зарим алхамуудыг хийжээ.

Гэвч “УБТЗ” ХНН-ийн тарифын бодлогын шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн одоогийн мөрдөж буй тогтоогдсон ихэнх үнэлгээ нь тээврийн үйлчилгээний ашигт ажиллагааны түвшинг хангахааргүй, ачаа тээвэрлэлтийн бодит өөрийн өртгийн тооцоонд үндэслэгдээгүй байна.

2007 оны төмөр замын ачаа тээврийн дундаж тариф 1 тн/км-т 0.012 ам.доллар байгаа нь бусад орны төмөр замын тарифтай харьцуулахад ихээхэн бага бөгөөд энэхүү үнэлгээ ОХУ-д 0.034 ам.доллар, БНХАУ-д 0.038 ам.доллар байна.

5. “УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооны 2007 оны 4 дүгээр сарын 11-14-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн 4, 4.3 дахь шийдвэрээр хувь нийлүүлэгчдэд хуваарилах болон төлөх ашгийн хэмжээг тогтоожээ.

6. “УБТЗ” ХНН-ийн 1999-2007 онд гадаад валютаар авсан урт хугацаат зээлийн өрийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийж бүртгэлд тусгаагүйгээс 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх тайлант хугацаанд ханшийн зөрүү 30,604,641.0 мянган төгрөгт хүрчээ. Тэнцэлд тусгаагүй ханшийн зөрүү “УБТЗ” ХНН-ийн 2007 оны 12 дугаар сарын 31-нээрх валютаар илэрхийлэгдэх урт хугацаат зээлийн үлдэгдлийн 60.0 хувьд хүрчээ.

7. 2006-2007 онд өмнөх онуудын адил орон сууцны хувьчлалын явцад өртөг өндөртэй түлш ашигладаг уурын зуух, дулаан дамжуулах төвийг нийгэмлэгийн балансаас хасаж шилжүүлээгүй байна. Хувьчлалаар орон нутгийн захиргаанд шилжүүлсэн орон сууцнуудын халуун ус, дулааны хангамжид зарцуулагдаж буй нийгэмлэгийн алдагдлын хэмжээ 2006 онд 800.5 сая төгрөг, 2007 онд 575.0 сая төгрөг болж байна.

8. “УБТЗ” ХНН-ийн 2005 оны агуулахад байгаа хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, бараа, бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 2006 онд 1.4 дахин, 2007 онд 1.5 дахин өсчээ.

9. Импортын машин, тоног төхөөрөмж, материал, бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээг өмнөх жилүүдэд гарч байсны адилаар өндөр эрсдэлтэй байгуулсан байна. (гэрээний 80.0 гаруй хувь нь 50-100 хувийн урьдчилсан төлбөр хийх нөхцөлтэй хийсэн байна)

“УБТЗ” ХНН-ийн санхүүгийн нөөцийн хомсдолтой байдал нь худалдан авах бараа, материалын үнийг төлөх төлбөрийн хугацаа зөрчигдөж, нэмэлт зардал гаргахад хүргэж байна.

10. “УБТЗ” ХНН нь санхүү, эдийн засгийн шаардлагатай нөөцгүйгээс тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөдлөх бүрэлдэхүүний засварын баазыг бэхжүүлэх 2005-2008 оны төлөвлөгөө хэрэгжээгүй байна.

2005 оноос 2006 оны хөрөнгө оруулалт 2.5 дахин, их засварт зориулах хөрөнгийн хэмжээ 12.0 хувиар буурсан ба 2007 онд хөрөнгө оруулалт 1.7 дахин, их засварт зориулсан хөрөнгийн хэмжээ 22.0 хувиар тус тус буурчээ.

11. Монгол-Оросын “УБТЗ” ХНН-ийн өмнө зөвхөн төмөр замын дэд бүтцийг шинэчлэн сайжруулах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг эрэлхийлэх, олохоос гадна ашиглалтад байгаа үндсэн хөрөнгийн техникийн нөхцлийг сайжруулах, замын нэвтрэх чадварыг дээшлүүлэх санхүүгийн нөөц шаардлагатай байна.

#### **Санал:**

Шалгалтын үр дүнгийн талаар

- Монгол Улсын Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам;
- Оросын Холбооны Улсын Холбооны Төмөр замын тээврийн агентлаг;
- Монгол Улсын Их Хурал;
- Оросын Холбооны Улсын Холбооны хурлын Төрийн Дум;
- Оросын Холбооны Улсын Холбооны хурлын Холбооны зөвлөлд тус тус мэдээлэх.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ

Б.БАТБАЯР

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН  
ТООЦООНЫ ТАНХИМЫН  
АУДИТОР

В.С.КОСОУРОВ